



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эдийн засаг, хөгжлийн яамны 2025-2028 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг нэгжийн дарга нарт, хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Төрийн нарийн бичгийн дарга (И.Батхүү)-д тус тус үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/54 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Л.ГАНТӨМӨР



240866



Эдийн засаг, хөгжлийн сайдын
2025 оны 01 дугаар сарын 03-ны
өдрийн А/01 дугаар тушаалын
хавсралт



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028 ОН)

Улаанбаатар хот

2025 он

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт	4
Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлтийн бүтэц, хувь	54
Хүснэгт 3: Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт /сүүлийн 5 жилээр/	57
Хүснэгт 4. Бизнес эрхлэхүй судалгаагаар Монгол Улсын муу үзүүлэлтүүд	71
Хүснэгт 5. Бизнес эрхлэхүй судалгааны дэд бүлгүүд дэх Монгол Улсын эрэмбэ болон оноо	72
Хүснэгт 6. Орчны шинжилгээ	74
Хүснэгт 7. Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт	76
Хүснэгт 8. "Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	76
Хүснэгт 9. Оролцогчдын шинжилгээ	76
Хүснэгт 10. Нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажилласан байдал	77
Хүснэгт 11. Олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан байдал	77
Хүснэгт 12. Холбогдогч талуудын оролцоо	78
Хүснэгт 13. Санхүүгийн нөөц, батлагдсан төсөө, сая төгрөгөөр	78
Хүснэгт 14. Давхардсан чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагууд	79
Хүснэгт 15. Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	82
Хүснэгт 16. Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэг, захиргааны эрх хэмжээний ангиллаар	91
Хүснэгт 17. Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам	103
8.1. Эдийн засаг, хөгжлийн яамны бүтэц	131
8.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын бүтэц	132

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Албан хаагчдын насны судалгаа.....	48
Зураг 2. Яамны албан хаагчдын боловсролын зэрэг	48
Зураг 3. Яамны албан хаагчдын ажил, мэргэжлийн жагсаалт.....	49
Зураг 4. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар	
Зураг 5. Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагаанд холбогдогч талууд	77

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү стратеги төлөвлөгөөг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримтлан боловсруулсан.

Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэн батлагдсантай холбогдуулан ерөнхий чиг үүрэг болох бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, салбар дундын бодлого, зохицуулалтын уялдааг хангах, макро эдийн засгийн судалгаа шинжилгээ, бодлого, төсөөлөл гаргах, шинжлэх ухаан, технологи, эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны бодлого, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төр, хувийн хэвшлийн түншлэл, ногоон санхүүжилт, салбаруудын шинэчлэлийн бодлого, хөгжлийн төслийн бодлого, төрийн захиргааны манлайлал, хяналт-шинжилгээ, үнэлгээ тэдгээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн.

Иймд Эдийн засаг, хөгжлийн яам (2025-2028 он)-ны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулав.

Стратеги төлөвлөгөөнд Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарах 9 ерөнхий чиг үүргийн 24 зорилт, 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь тухайн салбарын хуулиар олгогдсон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа 32 хуулиас тухайн салбарт 18, нийтлэг мөрдөгдөж буй 14 хуульд туссан байна. Дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		32	
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо -18	1	Монгол Улсын Үндсэн хууль
		2	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
		3	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль
		4	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
		5	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль

		6	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль	
		7	Инновацын тухай хууль	
		8	Технологи дамжуулах тухай хууль	
		9	Хөрөнгө оруулалтын тухай хууль	
		10	Төсвийн тухай хууль	
		11	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль	
		12	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	
		13	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль	
		14	Олон улсын гэрээний тухай хууль	
		15	Өрийн удирдлагын тухай хууль	
		16	Гадаадын иргэний эрхзүйн байдлын тухай хууль	
		17	Зөвшөөрлийн тухай хууль	
		18	Оюуны өмчийн тухай хууль	
		Нийтлэг мөрддөг хуулийн тоо-14	19	Төрийн албаны тухай хууль
			20	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
			21	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
			22	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
			23	Төрийн болон албаны нууцын тухай хууль
	24		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	
	25		Төрийн хэмнэлтийн тухай хууль	
	26		Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	
	27		Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	
	28		Шилэн дансны тухай хууль	
	29		Хөдөлмөрийн тухай хууль	
	30		Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль	
	31		Авлигын эсрэг хууль	
	32		Захиргааны ерөнхий хууль	
	33		Холбогдох бусад хуулиуд	

Ерөнхий чиг үүрэг 1. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх
Үндсэн чиг үүрэг 1.1. Монгол Улсын урт, дунд,	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв,

богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу бүс нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэл, нийгмийн хөгжлийн бодлого, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд холбогдох мэдээллээр яамны бусад нэгжийг хангах;	төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах;	төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагууд, Олон улсын байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд
Үндсэн чиг үүрэг 1.2. Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, салбар хоорондын бодлогыг уялдуулж, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгөх;	
Үндсэн чиг үүрэг 1.3. Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлого, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх.	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;	
	Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах;	
	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх;	
	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийг эргэлтэд оруулах;	
	Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;	
	Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах;	
	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;	

	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал өгөх;	
	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судлах, нутагшуулах, хөгжүүлэлтийг дэмжих.	
Ерөнхий чиг үүрэг 2. Макро эдийн засгийн судалгаа, шинжилгээнд суурилсан бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн ирээдүйн төсөөлөл, төлөвлөлт хийх.		
Үндсэн чиг үүрэг 2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой өсөлтийг хангах бодлогын чиглэлийг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт хийх, эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний санал, төлөвлөгөө боловсруулах; Үндсэн чиг үүрэг 2.2. Макро эдийн засгийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой өсөлтийг хангах бодлогын чиглэлийг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт хийх, эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний санал, төлөвлөгөө боловсруулах;	Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;	Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, Монгол банк, Үндэсний статистикийн хороо Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, Их, дээд сургуулиуд, холбогдох судалгаа, шинжилгээний байгуулга, хүрээлэнгүүд
	Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийх;	
	Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох	
	Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;	
	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;	

Үндсэн чиг үүрэг 2.3. Улсын эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор нэгдсэн тооцоолол, судалгаа, шинжилгээнд үндэслэн холбогдох бүх шатны төрийн байгууллагуудыг бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалт, зөвлөмжөөр хангах.	Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.	
Ерөнхий чиг үүрэг 3. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох.		
Үндсэн чиг үүрэг 3.1. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох;	Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, Монгол банк, Үндэсний статистикийн хороо Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, Их, дээд сургуулиуд, холбогдох судалгаа, шинжилгээний байгуулга, хүрээлэнгүүд, Оюуны Өмчийн газар
Үндсэн чиг үүрэг 3.2. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, шинжлэх ухааны судалгааны төслийн буцалтгүй тусламж, санхүүжилтийг удирдах	
Үндсэн чиг үүрэг 3.3. Шинжлэх ухааны нотолгоонд суурилсан дэвшилтэт технологи, инновацыг тэргүүлэх салбаруудад нутагшуулах замаар эдийн засгийн эрчимтэй хөгжлийг бий болгох бодлого, зохицуулалт хийх;	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй, хүртээмжтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох; Шинжлэх ухааны судалгаа, дэвшилтэт технологи, инновацыг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлого боловсруулах, зохицуулах.	
Ерөнхий чиг үүрэг 4. Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох, тохиролцох.		

Үндсэн чиг үүрэг 4.1. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих; Үндсэн чиг үүрэг 4.2. Импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, шинээр гэрээ хэлцэл байгуулах санал гаргах, боловсруулах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; Үндсэн чиг үүрэг 4.3. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтжан ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах; Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангах; Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлон, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавих; Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ өвч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; Нэгжийн худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах чиглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавих;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлүүд болон их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэд, ОУБ, хөрөнгө оруулагчид болон бусад байгууллага
---	---	--

ажиллагааг хөгжүүлэх, яамны гадаад харилцааны асуудлыг эрхлэн гүйцэтгэх;		
Ерөнхий чиг үүрэг 5. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, ногоон санхүүжилтийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх.		
Үндсэн чиг үүрэг 5.1. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;	Хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, ногоон санхүүжилт татах таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах; Хөрөнгө оруулалтын тухай, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын олон улсын гэрээ байгуулах асуудлаар санал боловсруулах; Хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, олон улсын байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, төр, хувийн хэвшил, Төрийн бус байгууллага, төслийн нэгж, харьяа байгууллагууд

Үндсэн чиг үүрэг 5.2. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хөрөнгө оруулалтын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн төслүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулж төслийн санхүүжилтийн төлөвлөлт, эдийн засаг, санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх, бэлэн байдал хангагдсан төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;
Үндсэн чиг үүрэг 5.3. Ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах арга хэмжээ, ногоон эдийн засаг, тогтвортой санхүүжилтийн бодлогыг салбарын яамтай уялдуулан боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эх үүсвэр татах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг тодорхойлох, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих цогц арга хэмжээг зохион байгуулах;	Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;

Үндсэн чиг үүрэг 5.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээг холбогдох хууль, журамд заасны дагуу салбарын яам, түншлэлийн төвөөр хийлгэх, хамтран оролцох, хяналт тавих, түншлэлийн төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах, түншлэлийн төслийн саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, түншлэлийн төслийн уралдаант сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээний биелэлт, явц, үр дүнд хяналт тавих арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах; Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавих.	
Ерөнхий чиг үүрэг-6. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах.		
Үндсэн чиг үүрэг 6.1. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Аж үйлдвэрийн төлөвлөлтийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, олон улсын байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, төр, хувийн хэвшил, Төрийн бус байгууллага, төслийн нэгж, харьяа байгууллагууд, аж ахуйн нэгж

Үндсэн чиг үүрэг 6.2. Салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийх, бизнесийн орчныг дэмжих, учирч буй хүндрэлийг бууруулах, өмчийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого зохицуулалт хийх, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, тэдний санал гомдлыг хүлээн авах мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, холбогдох төрийн байгууллагуудад санал боловсруулах, жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих, бойжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн олон талт, бодитой арга хэмжээг хэрэгжүүлэх;	Эдийн засгийн салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийх, салбаруудын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, либералчлахын бодлогыг тодорхойлж, холбогдох байгууллагууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдтэй хамтатган үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Хувийн хэвшлийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад төрийн оролцоог багасгах үндсэн чиглэлийн бодлого боловсруулах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;
Үндсэн чиг үүрэг 6.3. Аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлтийг орон зайн судалгаанд тулгуурлан тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, орон зайн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;	Жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих бодлого, тогтолцоог хөгжүүлж, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;	
Ерөнхий чиг үүрэг-7. Яамны хэмжээнд өөрчлөлтийн удирдлагын үр нөлөөтэй арга барил, туршлага нэвтрүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг бий болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх.		
Үндсэн чиг үүрэг-7.1. Яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж, тайлагнах, хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулах, тайлагнах, аппаратын дотоод ажлыг эрхлэх, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх,	Яамны бодлого, үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн харилцааг зохицуулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах; Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих; Эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллагууд, бусад холбогдох байгууллага, яамны дотоод бүтэц, зохион байгуулалтын нэгжүүд, харьяа байгууллага, Төрийн бус байгууллага, Төр, хувийн хэвшлийн түншлэл, агентлагууд болон бусад байгууллага

шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах, салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, байгууллагын санхүүг эрхлэх;	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлэх.	
Үндсэн чиг үүрэг-7.2. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах; Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх;	
Үндсэн чиг үүрэг-7.3. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах	

дээшлүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах;	хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	
Үндсэн чиг үүрэг 7.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохицуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, ерөнхийлөн захирагчийн болон яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах.	Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах;	
Ерөнхий чиг үүрэг-8. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх.		
Үндсэн чиг үүрэг 8.1. Улсын хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, зөвлөмж гаргах, биелэлтэд хяналт тавих, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон яамны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах;	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар ХХГ, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, дотоод нэгжүүд, харьяа байгууллагууд
	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;	
	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;	
	Яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж,	

	Засгийн газрын тогтоол, шийдвэрээр үүрэг болгосон ажил үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах; Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан яамны хариуцан болон хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах; Яамны дотоод нэгжүүд, сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангах, зохих арга хэмжээг авах талаар зөвлөмж өгөх.	
Ерөнхий чиг үүрэг-9. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийн дарааллыг тогтоон эрэмбэлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.		
Үндсэн чиг үүрэг 9.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, хянан баталгаажуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулах, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах,	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, эрэмбэлэх, хянан баталгаажуулах, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийлгэх, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах; Бэлэн байдал хангагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого тодорхойлох;	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, дотоод нэгжүүд, ОУБ, төслүүд болон бусад холбогдох байгууллагууд, ААН

эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавих;		
Үндсэн чиг үүрэг 9.2. Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангаж, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулж, эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах;	Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулах;	
Үндсэн чиг үүрэг 9.3. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хөрш орнуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн чиглэлийг тодорхойлж, шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;	Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах;	
	Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавих.	

Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэг

№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хуулийн зүйл, заалт
Ерөнхий чиг үүрэг 1. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;			
1.	Үндсэн чиг үүрэг 1.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу бүс нутаг, салбар хоорондын уялдааг ханган	-хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах; -хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс,	1.Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.

боловсруулах, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэл, нийгмийн хөгжлийн бодлого, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд холбогдох мэдээллээр яамны бусад нэгжийг хангах; Үндсэн чиг үүрэг 1.2. Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, салбар хоорондын бодлогыг уялдуулж, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх; Үндсэн чиг үүрэг 1.3. Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлого, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх.	орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгөх; -нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах; -хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах; -олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх; -хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийг эргэлтэд оруулах; -улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх; -эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт	2.Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5-ын 1 дэх хэсэг -хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт; -хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого; -хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт; 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 9.3.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 9.3.6.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; 9.3.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам батлах; 9.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах; 9.4.2.Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулж, Засгийн газарт танилцуулах; 9.4.3.... улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх; 9.4.8.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах; 9.4.9.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн журам батлах; 9.12.4.дэлхийн улс орнуудын туршлага, арга хөгжлийн чиг хандлагыг судалж өөрийн орны
--	--	--

	нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах; -хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулах; -аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал өгөх; -хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судлах, нутагшуулах, хөгжүүлэлтийг дэмжих.	онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх; 9.12.6.олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулах, дэвшилтэт техник, технологи, багаж хэрэгсэл ашиглах, судалгаа шинжилгээний хамтарсан арга хэмжээ зохион байгуулах; 22.1.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө. 22.2.Мэдээллийн нэгдсэн санд эрх бүхий байгууллагын баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнтэй холбогдох тайлан, судалгаа, шинжилгээ, тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлнэ. 22.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь холбогдох эрх зүйн акт, тайлан, дүгнэлт, судалгаа, шинжилгээ, баримтаар баталгаажсан байна. 22.5.Мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, мэдээллийн сангийн ангилалт, бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, программчлал, хөгжлийн загвар боловсруулалт, шинэчлэлийг хариуцан зохион байгуулна.
Ерөнхий чиг үүрэг 2. Макро эдийн засгийн судалгаа, шинжилгээнд суурилсан бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн ирээдүйн төсөөлөл, төлөвлөлт хийх		

2.	Үндсэн чиг үүрэг-2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой өсөлтийг хангах бодлогын чиглэлийг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт хийх, эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний санал, төлөвлөгөө боловсруулах; Үндсэн чиг үүрэг 2.2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулах, төсөв, төрийн санхүүгийн төлөв байдлыг тодорхойлох, төсөөлөл боловсруулах, тулгарч болох болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний санал, төлөвлөгөө боловсруулах; Үндсэн чиг үүрэг 2.3. Улсын эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор нэгдсэн тооцоолол, судалгаа, шинжилгээнд үндэслэн холбогдох бүх шатны төрийн байгууллагуудыг бодлогын нэгдсэн	Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох; Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох; -Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах; -Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах; -Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх; Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа,	4.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль 20 дугаар зүйл 5.1 Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд; макро эдийн засгийн бодлогын судалгаа, төлөвлөлт; 5. Төсвийн тухай хууль 28.3.Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно: 28.3.2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж; 28.3.3.нийгмийн ач холбогдол; 28.3.4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл; 32.2.Төсвийн төслийн танилцуулгад дараах зүйлийг тусгана: 32.2.1.макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо; 32.2.2.макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас тухайн жилд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг төсвийн төсөлд тусгасан байдал; 6.Төсвийн тогтвортой байдлын хууль, 12.3.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах агуулгатай байна: 12.3.3.макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ; 12.3.4.өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт, ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны урсгал тэнцлийн талаарх макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд; 12.3.5.макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцоход хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл; 7.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль,
-----------	--	---	---

	удирдлага, зохицуулалт, зөвлөмжөөр хангах.	шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.	9.4.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг: 9.4.3.макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;
--	---	--	---

Ерөнхий чиг үүрэг-3. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох;		
3.	Үндсэн чиг үүрэг 3.1. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох; 8. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль 20 дугаар зүйл 5.1 Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд:-шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт; -оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал; 9. Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг; 38.2. 2/-т Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; 10. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 5.1. Шинжлэх ухаан технологи, инновацыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн урт, дунд, богино хугацаагаар төлөвлөж, хэрэгжүүлнэ. 5.2.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх урт хугацааны зорилго, зорилтыг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусган, хэрэгжүүлнэ. 5.3.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх урт хугацааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрт, таван жилийн зорилго, зорилт, арга хэмжээг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд, жил бүрийн зорилт, үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тус тус тусган хэрэгжүүлнэ. 7.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх таван жилийн зорилго, зорилт, арга хэмжээг аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд, жилийн зорилт, үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлнэ. 7.2.Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, энэ хуулийн 10.1.3-т заасан шинжлэх ухаан, технологийн жилийн нарийвчилсан төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.

		10.1.1.шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах; 10.1.4.үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тооцож, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; 12.3.Асуудал эрхэлсэн Засгийн гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 12.1-д заасан тогтоол, зөвлөмжийг холбогдох хөгжлийн бодлогын баримт бичгийн болон төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх, эсхүл өөрийн бүрэн эрхийн хүрээнд асуудлыг шийдвэрлэн, хэрэгжилтийг хангаж ажиллана. 15.1.1.шинжлэх ухаан, технологийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 15.1.12.6.шинжлэх ухаан, технологийн статистик мэдээлэл, шалгуур үзүүлэлтийг дотоод, гадаадын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа, судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнтэй харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх, шинжлэх ухаан, технологийн бодлогыг боловсруулан, хэрэгжүүлэхэд ашиглах; 15.1.2.шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх; 15.1.27.шинжлэх ухаан, технологийн төслийн өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмыг батлах; 11. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 6.5.8.шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр.
Үндсэн чиг үүрэг 3.2. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, шинжлэх ухааны судалгааны төслийн буцалтгүй тусламж, санхүүжилтийг удирдах;	12. Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг; 38.2. 2/-т Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; 13. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 5.1. Шинжлэх ухаан технологи, инновацыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн урт, дунд, богино хугацаагаар төлөвлөж, хэрэгжүүлнэ. 5.3.Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх урт хугацааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан,

			технологийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрт, таван жилийн зорилго, зорилт, арга хэмжээг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд, жил бүрийн зорилт, үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тус тус тусган хэрэгжүүлнэ. 15.1.1. шинжлэх ухаан, технологийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулах; 15.1.2. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулах, хэрэгжүүлэх; 15.1.3. бүс, орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх асуудлаар энэ хуулийн 7.1-д заасан баримт бичгийн төсөлд саналаа хүргүүлэх; 15.1.4. энэ хуулийн 5.3-т заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх; 15.1.5. үндэсний шинжлэх ухаан, технологийн санг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, жилийн тайлан, төлөвлөгөөг хэлэлцэх; 15.1.6. үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь болон хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлын чиглэл, санхүүжилтийг батлах; 15.1.7. бусад төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагыг шинжлэх ухаан, технологийн талаарх чиг үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах; 15.1.9. эрдэм шинжилгээний байгууллага болон судалгаа хөгжүүлэлтийн төслийг үнэлэх; 15.1.13. төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох; 15.1.23. төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх; 15.1.24. салбар дундын ашиглалттай нээлттэй лабораторийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг батлах; 15.1.25. төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон оюуны өмчид хамаарах бүтээгдэхүүнийг хууль, гэрээнд заасны дагуу хүн, хуулийн этгээдэд ашиглуулсны төлбөр авах журмыг батлах; 4 дүгээр бүлэг. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн дэмжлэг
--	--	--	---

		21 дүгээр зүйл.Үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийг боловсруулах, батлах, дэмжлэг үзүүлэх 22 дугаар зүйл.Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлт, технологийн хөгжлийг дэмжих 23 дугаар зүйл.Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг дэмжих 24 дүгээр зүйл.Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааг дэмжих 14. Инновацын тухай хууль 7.1.1.үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 7.1.3.төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас инновацыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах; 7.1.5.инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах; 7.1.12.инновацыг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах; 7.1.13.инновацын үйл ажиллагааг урамшуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх; 11.1.1.орон нутагтаа инновацыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах, хамтарсан санхүүжилттэй инновацын төсөл хэрэгжүүлэх; 11.1.2.аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгуулагдсан паркийн хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нийгмийн дэд бүтэц байгуулах, суурь үйлчилгээ үзүүлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр шийдвэрлэх, паркийн захиргаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах; 11.1.5.инновацын үйл ажиллагааг дагнан эрхлэх үүрэгтэй орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулж ажиллуулах;
Үндсэн чиг үүрэг 3.3. Шинжлэх ухааны нотолгоонд суурилсан дэвшилтэт технологи, инновацыг тэргүүлэх салбаруудад нутагшуулах замаар эдийн засгийн эрчимтэй хөгжлийг бий болгох бодлого, зохицуулалт хийх;	-Шинжлэх ухаан, технологийн судалгаа, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй, хүртээмжтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох; -Шинжлэх ухааны судалгаа, дэвшилтэт технологи, инновацыг эдийн засгийн	15. Инновацын тухай хууль 6.1.1.төрөөс инновацын талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 6.1.2.инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах; 6.1.3.инновацын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 6.1.4.үндэсний инновацын тогтолцоо, инновацыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах; 6.1.5.төрөөс инновацыг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон нийтээр дагаж

		тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлого боловсруулах, зохицуулах.	мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах; 7.1.1.үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах; 7.1.2.инновацын тэргүүлэх чиглэл, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрт шаардагдах төсвийн санхүүжилтийн талаар санал боловсруулж Засгийн газарт өргөн барих; 7.1.3.төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас инновацыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах; 7.1.4.инновацын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэхэд оролцогч талуудын түншлэл, үйл ажиллагааны уялдааг хангах бодлогыг хэрэгжүүлэх; 7.1.12.инновацыг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах; 7.1.16.шинжлэх ухаан, технологийн салбарт инновацыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; 13.1.Шинжлэх ухаан, технологийн ололтыг эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, өндөр технологийн болон өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, өндөр үр ашигтай үйлчилгээний төрөл, хэлбэрийг бий болгоход чиглүүлэх, инновацын үйл ажиллагааны чадавх, нөөцийг оновчтой байршуулах, төрийн дэмжлэгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор инновацын тэргүүлэх чиглэлийг тогтооно. 16.4.1.технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффис гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг төрөөс татварын бодлогоор дэмжих; 16.4.2.энэ хуулийн 16.4.1-д заасан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батлах. 16. Технологи дамжуулах тухай хууль 6.1.2.технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран эрх олгох, холбогдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх; 6.1.4.тэргүүний технологи нэвтрүүлэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран төсөл зарлаж шалгаруулах, тэргүүний технологи ашиглах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал, санаачилгыг дэмжих; 7.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглаж байгаа технологийнх нь улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль
--	--	---	---

		орчинд хохирол учруулбал, эсхүл тухайн чиглэлийн технологи дамжуулахыг хянаж байхаар Засгийн газар хоорондын болон Монгол Улсын нэгдсэн бусад олон улсын гэрээ хэлэлцээрт заасан бол уг технологид төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан эрдэм шинжилгээний байгууллагаар үнэлгээ хийлгүүлнэ. 7.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь шинээр хэрэглэх технологийн түвшинд 7.1-д заасан байгууллагаар үнэлгээ хийлгүүлж болно. 7.4.Технологийн түвшинг үнэлэх эрдэм шинжилгээний байгууллага нь үнэлгээ хийж байгаа технологийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд хийсэн үнэлгээнийхээ талаар батламж гаргана. 7.6.Технологийн түвшний үнэлгээ хийсний дараа тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн технологийг цаашид ашиглахыг хориглох талаар шийдвэр гаргаж болно. 7.7.Технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. 17. Оюуны өмчийн тухай хууль 12.1.1.оюуны өмчийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 12.1.2.оюуны өмчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх талаар санал боловсруулах; 12.2.1.зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч, эсхүл түүнд хамаарах эрх эзэмшигчийн хүсэлтээр зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг бүртгэх, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, бүтээлийн сан бүрдүүлэх; 12.3.1.аж үйлдвэрийн өмчийн эрхэд хамаарах бүтээлийн мэдүүлэг хүлээн авах, хянах, хайлт, мөн чанарын шүүлт хийх, бүртгэх; 12.3.2.аж үйлдвэрийн өмчийн эрхэд хамаарах бүтээлийн бүртгэл хөтөлж, патент, гэрчилгээ олгох, хүчингүй болгох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
Ерөнхий чиг үүрэг-4. Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох, тохиролцох.		

4.	Үндсэн чиг үүрэг 4.1. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих; Үндсэн чиг үүрэг 4.2. Импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, шинээр гэрээ хэлцэл байгуулах санал гаргах, боловсруулах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;	-Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах; - Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, салбар хоорондын уялдааг хангах; -Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлох, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих; -Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ,	18.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 5 дугаар хэсгийн 1 дэх хэсэг, -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд; -эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлого; 19. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль 6.6 Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож байгаа гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ. 20. Галт зэвсгийн тухай хууль 16 дугаар зүйл. Галт зэвсэг, сум импортлох, нийтэд худалдах 16.3.Хууль зүйн, спорт, байгаль орчин, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, цагдаа, гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн комисс /цаашид "Комисс" гэх/ сонгон шалгаруулалтыг эрхлэн гүйцэтгэнэ. 21. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 7.2. Эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, хил, гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллага нь салбарын чиг үүрэгтэй уялдсан химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн сантай байх бөгөөд эдгээр нь энэ хуулийн 7.1-д заасан мэдээллийн нэгдсэн сангийн бүрэлдэхүүнд багтаж түүнтэй сүлжээгээр холбогдсон байна. 22. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 6.3.Зөвлөлийн бүрэлдэхүүнд гааль, татвар, төсөв, санхүү, гадаад худалдааны болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс гадна эрдэм шинжилгээ, судалгааны болон ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулна.
----	--	--	---

	Үндсэн чиг үүрэг 4.3. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, яамны гадаад харилцааны асуудлыг эрхлэн гүйцэтгэх;	хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авах, хэрэгжилтэд хяналт тавих; -Нэгжийн худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавих.	
--	--	---	--

Ерөнхий чиг үүрэг-5. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, ногоон санхүүжилтийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх.

5.	Үндсэн чиг үүрэг-5.1. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;	-Хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, ногоон санхүүжилт татах таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах; -Хөрөнгө оруулалтын тухай, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын олон улсын гэрээ байгуулах асуудлаар санал боловсруулах;	19.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 5 дугаар хэсгийн 1, -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд: -хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт; -төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал; 20. Хөрөнгө оруулалтын тухай хууль, -Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, 21.Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, 22.Засгийн газрын 2014 оны 52 дугаар тогтоолын хавсралт Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам, 23.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
----	---	---	--

Үндсэн чиг үүрэг-5.2. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хөрөнгө оруулалтын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн төслүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулж төслийн санхүүжилтийн төлөвлөлт, эдийн засаг, санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх, бэлэн байдал хангагдсан төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; -Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;
--	--

Үндсэн чиг үүрэг-5.3. Ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах арга хэмжээ, ногоон эдийн засаг, тогтвортой санхүүжилтийн бодлогыг салбарын яамтай уялдуулан боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эх үүсвэр татах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг тодорхойлох, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих цогц арга хэмжээг зохион байгуулах;	Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;	
--	---	--

Үндсэн чиг үүрэг 5.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээг холбогдох хууль, журамд заасны дагуу салбарын яам, түншлэлийн төвөөр хийлгэх, хамтран оролцох, хяналт тавих, түншлэлийн төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах, түншлэлийн төслийн саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, түншлэлийн төслийн уралдаант сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээний биелэлт, явц, үр дүнд хяналт тавих арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах; -Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавих;	24.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль,
Ерөнхий чиг үүрэг-6. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;		

6.	Үндсэн чиг үүрэг 6.1. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих; Үндсэн чиг үүрэг-6.2. Салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийх, бизнесийн орчныг дэмжих, учирч буй хүндрэлийг бууруулах, өмчийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого зохицуулалт хийх, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, тэдний санал гомдлыг хүлээн авах мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, холбогдох төрийн байгууллагуудад санал боловсруулах, жижиг, дунд болон	Аж үйлдвэрийн төлөвлөлтийн бодлогыг орон зайн судалгаанд суурилан тодорхойлох, орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;	25.Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд: 20 дугаар зүйлийн 5/1 дахь хэсэг, - эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, төслүүдийн нэгдсэн бодлого; - аж үйлдвэрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт; 26.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль -22.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө; -9.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах; 27.Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2.Энэ зүйлийн 1-д заасан зөвшөөрлийн нэгдсэн санг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. 28.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хуулийн 15.1.3.жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх 16.1.4.жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлүүлэх.
----	---	--	--

	гарааны бизнесийг дэмжих, бойжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн олон талт, бодитой арга хэмжээг хэрэгжүүлэх; Үндсэн чиг үүрэг 6.3. Аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлтийг орон зайн судалгаанд тулгуурлан тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, орон зайн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;	Хувийн хэвшлийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад төрийн оролцоог багасгах үндсэн чиглэлийн бодлого боловсруулах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах; Эдийн засгийн салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийж, салбаруудын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, либералчлалын бодлогыг тодорхойлж, холбогдох байгууллагууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдтэй хамтатган үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих; Жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих бодлого, тогтолцоог хөгжүүлж, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах.	
Ерөнхий чиг үүрэг-7. Яамны хэмжээнд өөрчлөлтийн удирдлагын үр нөлөөтэй арга барил, туршлага нэвтрүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг бий болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх.			
7.	Үндсэн чиг үүрэг-7.1. Яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх	29.Иргэдээс байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хууль 7 дугаар зүйл. 1.Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтан дараах нийтлэг үүрэг хүлээнэ: 1/иргэдээс өргөдөл,

тавьж, тайлагнах, хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулах, тайлагнах, аппаратын дотоод ажлыг эрхлэх, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах, салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, байгууллагын санхүүг эрхлэх; Үндсэн чиг үүрэг 7.2. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын	үйл ажиллагаанд хяналт тавих; Эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих; Яамны бодлого, үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн харилцааг зохицуулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах; Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлэх.	гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангах;2/харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг заавал хүлээн авах;3/өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх;4/өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;5/өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;6/өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх; 30.Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйл. 16.1.Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна. 16.2.Хууль тогтоомжийн төслийг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон 12.1.1-д заасан аргачлалын дагуу боловсруулна. 16.3.Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна. 16.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөл боловсруулах талаар төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч болно. 20.3.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төсөлдөө бусад төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллагын саналыг бичгээр авч, үндэслэлтэй гэж үзвэл тухайн төсөлд тусгана. 20.4.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлангийн хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ. Хууль тогтоомжийн төсөл төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах үр дагаврыг бий болгохоор бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ. 20.11.Энэ хуулийн 20.10-т заасан зөвшөөрлийг авсны үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.
--	---	--

хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	мэдээлэл, дэмжлэг үзүүлэх; Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;	20.12.Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан дэгийг баримтална. 31.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл. 6.1.Төрийн байгууллага энэ хуулийн 3.1.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараах нийтлэг үүрэг хүлээнэ: 6.1.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25-29 дүгээр зүйлд заасан нийтлэг үүрэг; 6.1.2.тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх; 6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах; 6.1.4.төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх; 6.1.5.тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах; 6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх; 6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх; 6.1.8.авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах; 6.1.9.төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах; 6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;
---	---	--

			6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх; 6.1.12.бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах; 6.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ. 6.3.Шүүх, прокурор, цагдаа, Авлигатай тэмцэх газар, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлаг байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно. 6.4.Энэ хуулийн 6.3-д заасан байгууллагын байранд улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 6.5.Авлигаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасан эрх, нийтлэг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ: 6.5.1.төрийн бус байгууллага гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж байх;
	Үндсэн чиг үүрэг 7.3.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах;	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	32.Төрийн албаны тухай хуулийн 17 бүлгийн 61 дүгээр зүйл. 61.1.Төрийн албан хаагч дараах нийтлэг баталгаагаар хангагдана: 61.1.1.албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах; 61.1.2.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах; 61.1.3.гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах; 61.1.4.албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах; 61.1.5.орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

		61.1.6.Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх; 61.1.7.төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах; 61.1.8.үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх; 61.1.9.ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох; 61.1.10.хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа. 61.2.Энэ хуулийн 61.1.5-д заасан баталгааг эдлүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар тогтооно. 62.1.4.төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлгийг тухайн байгууллагаас олгох. 33.Төрийн албаны тухай хууль 24.1.Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг тухайн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан төрийн албаны төв байгууллага, Засгийн газар хамтран батална. 29.1.Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна. 55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
Үндсэн чиг үүрэг-7.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг	Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв санхүүгийн	34.Төсвийн тухай хууль, 16.5.Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

зохицуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, ерөнхийлөн захирагчийн болон яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах.	мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах;	16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах; 16.5.8.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх. 16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.
Ерөнхий чиг үүрэг-8. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх.		
8. Үндсэн чиг үүрэг-8.1. Үндэсний хэмжээнд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах,	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах;	35.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль 5 дугаар бүлгийн 21 дүгээр зүйл. 21.1.Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана. 21.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино. 21.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ: 21.3.1.мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх; 21.3.2.зорилтын биелэлтийн дүнг үнэлэх; 21.3.3.биелэлтийн үр нөлөөг үнэлэх; 21.3.4.гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх; 21.3.5.төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх; 21.3.6.биелэлтийн түвшинг үнэлэх;

зөвлөмж гаргах, биелэлтэд хяналт тавих, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон яамны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах;		21.3.7.бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах. 36.Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 117.1.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ. 117.5.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно. 117.6.Энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланг Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна. 37.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол. 7.6.Үндэсний хэмжээнд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг: 7.6.1.Захиргааны байгууллага нь "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд; 7.6.2.Захиргааны байгууллага нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд; 7.6.3.Захиргааны байгууллага нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад,
--	--	---

		үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд; 7.6.5.Захиргааны байгууллага нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд;
	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;	38.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол. 4.4. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан, нэгжээс төлөөлөл оруулан хамтран ажиллана.
	Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;	39.Төсвийн тухай хууль 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх. 14.2.7.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; 40.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол. 7.6.6.Захиргааны байгууллага нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжилтийн тайланг нэгтгэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

	Яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр үүрэг болгосон ажил үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;	41.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол. 8.1. Захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг салбар, чиглэлээр ангилан энэ журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлнэ.
	Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан яамны хариуцан болон хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;	42.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9.6.Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг: 9.6.1.энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох; 9.6.2.энэ хуулийн 9.6.1-д заасан баримт бичигт тусгах саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлах, төлөвлөхөд шаардлагатай өөрийн эрхлэх асуудлын хүрээний тоо баримт, судалгаа, мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай гарган хүргүүлэх; 9.6.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг батлагдсаны дараа хэрэгжилтийг өөрийн салбарын хэмжээнд зохион байгуулах; 9.6.4.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хууль тогтоомжид заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлтийг Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

		Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	43.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7.1.4.төсвийн ерөнхийлөн захирагчаас яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх; 44.Монгол Улсын Яамны эрхзүйн байдлын тухай хууль. 3.3.Яам нь Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. 7.1.Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг ажил эрхэлнэ: 7.1.4.төсвийн ерөнхийлөн захирагчаас яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх; 45.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол. 9.5. Сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, улсын төсөвт байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
		Яамны дотоод нэгжүүд, сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангах, зохих арга хэмжээг авах талаар зөвлөмж өгөх.	46.Төсвийн тухай хууль 69.1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна. 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

		40.3.Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ. 47.Шилэн дансны тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 8 дугаар зүйлийн 8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ. 48.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол. 9.5. Сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, улсын төсөвт байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
Ерөнхий чиг үүрэг 9. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийн дарааллыг тогтоон эрэмбэлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.		
9. Үндсэн чиг үүрэг 9.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, хянан баталгаажуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулах, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах, эдийн засгийн	Хөгжлийн төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, эрэмбэлэх, хянан баталгаажуулах, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийлгэх, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах; Бэлэн байдал хангагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого тодорхойлох;	49.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 5 дугаар хэсгийн 1, -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд: - эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, төслүүдийн нэгдсэн бодлого; 50.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл. 8.1.3.Энэ хуулийн 20.4-т заасан төслийн бүрэн шинжилгээг хянаж, дүгнэлт гарган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах; 8.1.7.төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийн орчныг бэхжүүлэх, түншлэлийг хөгжүүлэх, түншлэлийн төсөлтэй холбогдуулан мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх; 8.1.8.түншлэлийн хууль тогтоомж, түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийн талаарх жилийн тайланг боловсруулж, Засгийн газарт жил бүр танилцуулах; 54.1.түншлэлийн гэрээний биелэлтэд төрийн түншлэгч этгээд болох төсөл хэрэгжүүлэх салбарын төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түншлэлийн

коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавих;	Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулах; Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах;	болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, уг гэрээний биелэлтийн талаар холбогдох арга хэмжээ авч, хамтран ажиллах үүрэгтэй.
Үндсэн чиг үүрэг 9.2. Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангаж, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулж, эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах;		51.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйл. 9.4.2.Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулж, Засгийн газарт танилцуулах; 9.4.4.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох; 9.4.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах; 9.3.6.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах; 9.4.11.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх; 9.12.4.дэлхийн улс орнуудын туршлага, арга хөгжлийн чиг хандлагыг судалж өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх;
Үндсэн чиг үүрэг 9.3. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хөрш орнуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн чиглэлийг тодорхойлж, шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;	Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавих. Эдийн засгийн коридорын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талын хамтарсан механизмын шугамаар хийгддэг уулзалтуудыг зохион байгуулах - Эдийн засгийн коридорын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээнүүдийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, "Бүс ба зам" санаачилгын төсөл, арга хэмжээнүүдтэй уялдуулан эрчимжүүлэх талаар	52."Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/ Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө. 4.4.3. Эдийн засгийн коридорын хүрээнд "Талын зам" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ. 4.4.4.Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот

	холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, Эдийн засгийн коридорын хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах	байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ. 53.УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” 1.2.1.2.ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх худалдаа, тээврийг хөнгөвчилсөн шинэ замнал /маршрут/-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болох; 1.2.1.6.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх боломжийг ашиглан төмөр замын сүлжээг өргөжүүлэх чиглэлийг тогтоосны үндсэн дээр Ази-Европыг холбосон өрсөлдөх чадвартай дамжин өнгөрүүлэх тээврийн шинэ замнал /маршрут/ бий болгох; 3.1.5.бүс нутгийн хөгжлийн хандлага: төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ нь төмөр замыг хөрш болон Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын үсрэнгүй хөгжиж байгаа дэд бүтэцтэй харилцан уялдаатай хөгжүүлж, уул уурхай, тээвэр, худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах боломжийг хангах; 7.1.4.хөрш орнуудын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарах төмөр замын шинэ гарц нэмэгдэн, эрэлт ихтэй гуравдагч орны зах зээлд ашигт малтмал шууд нийлүүлэх боломжтой далайн боомтуудад гарцтай болох; 7.1.6.Нийгэмлэгийг шинэчилж, ОХУ, БНХАУ-ын төмөр замтай холбосон төмөр замын шинэ замнал /маршрут/ нэмэгдэж, экспорт, импортын ачаа эргэлтийн хэмжээ үлэмж өсч, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх тээвэр нэмэгдэх.
--	--	--

ГУРАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Эдийн засаг, хөгжлийн яамны өнөөгийн байдлыг судалж, тулгамдсан асуудал цаашдын зорилтыг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд мандатын шинжилгээнд үндэслэн хийж гүйцэтгэв.

3.1. Салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал:

Засгийн газрын 2022 оны 75 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр байгуулагдаж, “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”,


орон тооны хязгаар 110-аар батлагдаж, нийт 10 газар, 8 хэлтэс, 76 албан хаагчтай үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, орон тооны хязгаар 135 болж шинэчлэгдэн батлагдсан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, орон тооны хязгаар 154 болж өөрчлөгдөн батлагдаж, нийт 9 газар, 19 хэлтэстэй байхаар шинэчлэгдсэн.

Албан хаагчдыг хүйсийн хувьд авч үзвэл, 47 эрэгтэй, 54 эмэгтэй, төрийн өндөр албан тушаал 2, улс төрийн албан тушаал 5, төрийн захиргааны албан тушаал 136, төрийн үйлчилгээний ангилалд 11 албан хаагч ажиллаж байна.


Яамны албан хаагчдын дундаж нас 36 байна.

Зураг 1. Албан хаагчдын насны судалгаа



Яамны нийт албан хаагчдын боловсролын зэргийг авч үзвэл давхардсан тоогоор дипломын болон бакалаврын дээд боловсролтой 117 албан хаагч байгаагаас бакалавр 57, магистр 57, докторын зэрэгтэй 3 албан хаагч байна. Эдийн засагч мэргэжлийн бакалаврын зэрэгтэй 20, магистр 14, нягтлан бодогч бакалаврын зэрэгтэй 5, магистр 7, эрхзүйч бакалаврын зэрэгтэй 9, магистр 17, санхүүгийн бакалаврын зэрэгтэй 4, магистр 5, бизнесийн удирдлагын бакалаврын зэрэгтэй 3, магистр 1, олон улсын харилцааны бакалаврын зэрэгтэй 6, магистр 1, бусад мэргэжлийн бакалаврын зэрэгтэй 10, магистрын зэрэгтэй 12 албан хаагч байна.

Зураг 2. Яамны албан хаагчдын боловсролын зэрэг



Зураг 3. Яамны албан хаагчдын ажил, мэргэжлийн жагсаалт



Өнөөгийн байдал:

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, орон тооны хязгаар 154 болж батлагдсанаас нийт 9 газар, 19 хэлтэс, 117 албан хаагч ажиллаж байна.

Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор сул орон тоог нөхөхөөр байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх, нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх, бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Байгууллагын хүний нөөцийн бодлогын дараах асуудлуудад төвлөрч ажиллаж байна.

1. Хүний нөөцийн удирдлагын хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хүний нөөцийн бодлогын бичиг баримт, төрийн албаны тухай хууль, тогтоомжид нийцүүлэн чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх, тухайн албан тушаалд хувь хүний мэдлэг, боловсрол мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагыг шалгуур болгон түүнийг хамгийн сайн хангаж байгаа хүнийг сонгон шалгаруулж томилох;
2. Сонгон шалгаруулах үндсийг тогтоосон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, зөвшөөрөл авах, батлуулах цаг хугацаа хүчин чармайлт шаардсан томоохон ажлыг хэрэгжүүлэн ажиллах;
3. Албан хаагчийн цалин хөлс, шагнал урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоог бүрдүүлэх;
4. Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой үр ашигтай байх зарчимд нийцүүлэх арга хэмжээ авах;

5. Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, томилох, сургаж хөгжүүлэх бодлого зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх;
6. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах;
7. Ёс зүйн үнэт зүйлсийг хэвшүүлэх.

Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

Хүний нөөцийн тулгамдсан асуудал:

- Хүний нөөцийн удирдлагын механизмыг сайжруулах;
- Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх;
- Удирдах албан тушаалтнуудын манлайллыг чадавхыг хөгжүүлэх;
- Хүний нөөцийн өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах;
- Төрийн албан хаагчдын цалин хөлс, урамшууллын системийг боловсронгуй болгох;
- Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг шийдвэрлэх;
- Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, удирдлагын чадавхыг хөгжүүлэх;
- Төрийн албан хаагчдад шинэ зан үйл, төлөвшүүлэх хэрэгцээг тодорхойлох;
- Төрийн албан хаагчдын карьерыг хөгжүүлэх тогтолцоог төлөвшүүлэх;
- Төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах механизмыг сайжруулах;
- Хүний нөөцийн удирдлагын асуудлаар гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Хүний нөөцийн мэдээллийн системийг сайжруулах;
- Хүний нөөцийн эрсдэлийн удирдлагын чадавхыг сайжруулах;
- Байгууллагын хүний нөөцийн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах;

Цаашдын зорилт:

- Яамны хүний нөөцийн удирдлагын зохицуулалтын механизм бүрдэн хэрэгжиж, төлөвших;
- Хүний нөөцийн менежментийн үр чадварыг бэхжүүлэх;
- Яамны хүний нөөцийн бодлого, хөрөнгө оруулалт стратегийн түвшнийг иж бүрэн тодорхойлж, эрсдэлийг багасгах;
- Хүний нөөцийн хуваарилалт сайжирч, боловсон хүчин мэргэшсэн тогтвортой болох;
- Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо төлөвшиж, яамны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө сайжрах;

- Удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавх дээшилж, байгууллагын зан үйлд өөрчлөлт гарах, улмаар “Суралцагч яам” болох;
- Нийт албан хаагчдын үнэт зүйл, мэдлэг чадвар дээшилж, цомхон бөгөөд гадаад, дотоод орчны өөрчлөлт, шаардлагад нийцэж чаддаг болох;
- Хүний нөөцийн бодлого болон гадаад хамтын ажиллагааны уялдаа холбоо хангагдах зэрэг болно.

3.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн өнөөгийн байдал:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь хэсэгт “Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-д заасан баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулж, Засгийн газарт танилцуулах,” гэж заасныг үндэслэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн төслийг боловсруулах, батлуулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1/ Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, ...хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан бөгөөд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 бодлогын чиглэлийн хүрээнд 16 зорилго, түүнийг хэрэгжүүлэх 620 зорилтыг тусгасан.

Хуульд заасны дагуу “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийг Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, мөн Засгийн газрын 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлуулав.

2/ Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу “Монгол

Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсрууллаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуультай "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд тусгагдсан төсөл, арга хэмжээг нийцүүлж тусгалаа.

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн 4 бодлогын чиглэл, 16 зорилго, 620 зорилтын хүрээнд нийт 1527 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа.

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нийт 196.96 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн тооцоо гарлаа. "Бүсчилсэн хөгжлийн бодлого"- хэрэгжүүлэхэд 36.06 их наяд төгрөг, "Хүний хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд 50.19 их наяд төгрөг, "Эдийн засгийн бодлого"-ыг хэрэгжүүлэхэд 102.14 их наяд төгрөг, "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого"-ыг хэрэгжүүлэхэд 8.57 их наяд төгрөгийг зориулах тооцоо гарлаа. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.

3/Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэгт "...4.1.13-д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах," гэж тус тус заасны дагуу "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Хамтарсан Засгийн газрын "Хурдтай хөгжлийн төлөөх зориг" гэрээг удирдлага болгон "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд "Урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх" зорилгыг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөлд нийт 314 төсөл, арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгалаа. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 5.2 их наяд төгрөг, гадаадын зээл, тусламжаар 4.2 их наяд төгрөг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 4.1 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.1 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээр 1.5 их наяд төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр тусгасан.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төслийг Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлууллаа.

Тулгамдаж буй асуудал: Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахад салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан тодорхой зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай байх зарчимд тулгуурлан төлөвлөх шаардлага байна.

Цаашдын зорилт:Дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр болох Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр, Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар батлуулах шаардлага байна.

Мөн дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар батлуулах шаардлага байна.

Дээрх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслүүдийг үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйд үндэслэн боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мөн дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулж, нэвтрүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулах, дэвшилтэт техник, технологи ашиглах шаардлага байна.

3.3. Эдийн засгийн өнөөгийн байдал:


Дэлхий дахиныг хамарсан цар тахал гарч, геополитикийн хямралт нөхцөл байдлын нөлөөгөөр манай улсын эдийн засгийн өсөлт 2020 онд -4.6 хувь болж буурсан бол 2023 онд 7.4 хувь, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 4.9 хувиар

өсөөд байна. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгох зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнд эдийн засгийн цар хүрээ тэлж, нэг хүнд ноогдох ДНБ 2023 онд 4870¹ ам.доллар хүрэв. Ингэснээр Дэлхийн банкны ангиллаар дунджаас дээгүүр орлоготой орны ангилалд багтаж, нийт 217 улсаас 122 дүгээр байрт шалгаран, 2022 оны ангиллаас 18 байраар ахисан болно. ДНБ 70.4 их наяд төгрөгт хүрч сэргэсний үр дүнд Засгийн газар хугацаа тулсан томоохон бондын төлбөрүүд болох Чингис, Мазаалай, Гэрэгэ болон Кредит Свис бондуудын өрийг бүрэн төлж, өрийн дарамтыг шийдвэрлэн, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагаас зээлжих зэрэглэл 2024 онд “В+, тогтвортой” болж сайжирсныг зарлаад байна.

Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлтийн бүтэц, хувь

Салбар	2020	2021	2022	2023	2024.III
Эдийн засгийн өсөлт	-4.6	1.6	5.0	7.4	5.0
ХАА	0.8	-0.8	1.7	-1.3	-3.5
Үйлдвэрлэл	-1.3	-0.6	-1.2	3.2	1.7
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах	0.3	-0.1	0.5	0.4	0.0
Цахилгаан, ус	0.0	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.1
Үйлчилгээ	-3.0	1.8	3.2	4.7	4.6
Худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.9
Тээвэр	-1.0	-0.3	0.4	1.8	0.9
Бусад	-0.6	1.5	1.7	2.1	2.9
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.1

Зураг 4. ДНБ-ий өсөлтийн бүтэц, улирлаар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Тулгамдаж буй асуудал: Манай эдийн засгийн бүтцийн дийлэнхийг уул уурхай, хөдөө аж ахуй, тээвэр, үйлчилгээ болон боловсруулах салбарууд бүрдүүлдэг. Сүүлийн 20 жилийн хугацаанд хөдөө аж ахуй, тээврийн салбаруудын эдийн засагт эзлэх хувь хэмжээ буурсан бол уул уурхай, санхүүгийн салбарын хувь хэмжээ нэмэгдсэн байна. Мөн дийлэнх экспортын орлого нь цөөн нэр төрлийн уул уурхайн түүхий эдээс бүрдэж, эдийн засаг гадаад зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс шууд хамаардаг бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь гол төлөв анхан шатны түүхий эд хэлбэрээр хийгдэж байна. Тухайлбал, 2023 оны гүйцэтгэлээр 15.2 тэрбум ам.долларын экспорт гадаад зах зээлд нийлүүлсэн бөгөөд үүний 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаар бүрдүүлжээ.

¹ Дэлхийн банкны атласын аргаар тооцсон дүн

Нөгөө талаас, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт, түүний өрсөлдөх чадвар, нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Сүүлийн 15 жилийн хугацаанд экспортын сагсанд 6 төрлийн бүтээгдэхүүн (цайрын хүдэр, хар тугалганы хүдэр, лаазалсан мах, хадгалсан мах, тосны ургамлын үр, ноосоор хийсэн нэхмэл даавуу) шинээр нэмэгдсэн нь бусад улс орнуудтай харьцуулахад ихээхэн сул үзүүлэлт юм. Иймд, эдийн засгийг төрөлжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох хүрээнд судалгаа, шинжилгээ боловсруулан, түүнд суурилсан бодлогын шийдвэр гаргах замаар эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх чухал шаардлагатай байна.

Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсан. Энэ хугацаанд төсвийн тухай хуульд 25 удаа тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулж, 12 удаа төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилсөн бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 18 удаа өөрчлөлт оруулсан байна. Төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор батлагдсан хуульд олон удаа өөрчлөлт оруулж, төсвийн хүрээний мэдэгдлийг байнга өөрчилж байгаа нь хууль тогтоомжийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Иймд төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангуулах хүрээнд хуулийг чандлан мөрдүүлэх, төсвийн төлөвлөлтийг макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн урт дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, төсвийн дүрмийг мөрдүүлэх, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна.

Монгол Улс 2024 онд Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр 176 улсаас 76 дугаарт, Дэлхийн өрсөлдөх чадварын индексээр 67 улсаас 61 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, томоохон төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олох зэрэг улс орны хөгжлийг дэмжихэд сөргөөр нөлөөлж байна. Иймд, эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлж, түүнд чиглэсэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр ажиллан олон улс дахь эрэмбийг сайжруулах нэн тэргүүний шаардлага үүсээд байна.

Цаашдын зорилт: Эдийн засгийн нийт үр ашиг, бүтээмж нэмэгдүүлэх чиглэлд хөдөө аж ахуйн салбарын татаас болон худалдааг нээлттэй болгох, эрчим хүчний салбарын либералчлахыг хийж, банк, санхүүгийн салбарыг олон улсад нээлттэй болгон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, боловсролын салбарыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах, эрүүл мэндийн салбарын үр ашгийг сайжруулах зэрэг салбарт чиглэсэн бодлогын цогц реформыг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн боловсруулалтын түвшнийг ахиулж холбогдох төслүүдийг хэрэгжүүлж, экспортын орлогоо нэмэгдүүлэх, нөгөө талдаа эдийн засгийн төрөлжилтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгосноор хөгжлийн бодлогын зорилго хангагдах боломж бүрдэх юм.

Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг бодитой, макро эдийн засгийн нөхцөлтэй уялдуулан боловсруулж, төсвийн алдагдлыг тогтвортой түвшинд хадгална. Төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай төсөлд чиглүүлэх замаар нийтийн санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. Ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн төсвийн сахилга бат, хяналтыг сайжруулна.

3.4. Шинжлэх ухаан технологийн бодлогын өнөөгийн байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн долоодугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна." гэж, гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 38.2 дахь хэсгийн 2/-т "Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхэд "шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" гэж тус тус хуульчлан заасан нь шинжлэх ухаан, технологийн талаарх Үндсэн хуулийн баталгаа юм.

Нөгөөтэйгүүр, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.7 дахь хэсэгт "Шинжлэх ухаан, технологийн хүний нөөц, дэд бүтэц, тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн." гэж; 3.7.1.1 дэх заалтад "шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоож, дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хүртэлх хувийг шинжлэх ухааны арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулах" гэж, мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7.1 дэх заалтад "Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ" гэж; Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.8 дахь заалтад "шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр" гэж Монгол Улсын хууль тогтоомж, хөгжлийн урт дунд хугацааны бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологийг улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндэс суурь мөн болохыг тодорхойлсон юм.

Энэхүү шинэчлэлийн эхлэл болгон Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар "Шинжлэх ухаан, технологийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг ёсчлон баталсан.

2024 оны байдлаар шинжлэх ухаан, технологийн салбарт Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Патентын тухай хууль зэрэг 20 гаруй хууль тогтоомж, дүрэм, журам бүхий хууль эрхзүйн актууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Шинжлэх ухааны салбарт яам, агентлагийн харьяа 17, шинжлэх ухааны академийн харьяа 16, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын 20, их сургуулийн харьяа 10, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн дэргэдэх 3, нийт 66 эрдэм шинжилгээний байгууллага (хүрээлэн, төв) шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

Дээрх байгууллагад нийт 6965 ажиллагчид, үүний 75.6 хувь буюу 5266 нь судлаачид, 17.8 хувь буюу 1243 нь эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байна.

Сүүлийн 30-аад жилийн хугацаанд шинжлэх ухаан, технологийн 4500 орчим төсөлд 178.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосны үр дүнд 51.5 мянган үр дүнг амжилттай нэвтрүүлсэн байна. Т/бал: шинэ бүтээлийн патент 352, ашигтай загвар 304, шинэ болон шинэчилсэн технологи 768, бүтээгдэхүүний загвар 700, зохиогчийн эрх 166, эрдэм шинжилгээний гадаад, дотоодод хэвлүүлсэн өгүүлэл 19510, үйлдвэрлэлд нэвтэрсэн үр ашиг 723 байна. Харин 2024 онд гэхэд л шинэ патент 74, шинэ технологи 21, биет бүтээгдэхүүн 100, зохиогчийн эрх 235, импакт фактор өндөртэй эрдэм шинжилгээний сэтгүүлд 720 өгүүлэл хэвлүүлсэн үр дүнг дурдаж болох юм.

Тулгамдаж буй асуудал: Дээр дурдсанаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.7.1.1 дэх заалтад “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоож, дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хүртэлх хувийг шинжлэх ухааны арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулах” гэж, мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.7.1 дэх заалтад “Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ.” гэсэн зорилт тавьсан хэдий ч сүүлийн 5 жил шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд зарцуулж буй судалгаа хөгжүүлэлтийн санхүүжилтийн хэмжээ нэг ч нэмэгдээгүй буюу 10-12 тэрбум орчим төгрөг, 2025 оны төсөвт мөн нэмэгдээгүй батлагдсан; сүүлийн 10 жилд 1 судалгаанд дунджаар жилд 14.8 сая.төгрөг ногдож байгаа нь шинжлэх ухаан, технологийн үр дүнд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, тус салбарын болоод хүний нөөцийн чадавх буурч, үр чадвартай эрдэмтэн, судлаачдаа гадагшаа алдах эрсдэл тулгарч байна.

Хүснэгт 3: Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилт /сүүлийн 5 жилээр/.

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Шинжлэх ухаан, технологийн салбарын нийт зардал /тэрбум төг/	51.1	46.5	50.7	49.3	71.0
Урсгал зардал	39.8	34.1	38.1	38.9	58.5
ЭША-ын зардал	11.3	12.3	12.6	10.4	12.4
ДНБ-д эзлэх хувь	0.11%	0.10%	0.12%	0.11%	0.15%

Иймд дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Нэгдүгээрт: нэн тэргүүнд шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх санхүүжилтийг 2025 онд ДНБ-ний 0,2 хувь, 2028 он гэхэд 1 хувьд хүргэх буюу зорилтот түвшинд хүргэхэд онцгой анхаарах; Хоёрдугаарт: Ур чадвартай эрдэмтэн, судлаачдын гадагш урсгалыг зогсоох тусгайлсан (зорилтот) хөтөлбөр хэрэгжүүлэх, цаашлаад нийгмийн баталгааг хангах, ажиллах орчныг олон улсын жишигт хүргэх нь чухал байна.

Цаашидын зорилт: Цаашид шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ” гэсэн зорилтыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. 2024 онд шинээр батлуулсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах;

2. Судалгаа шинжилгээний үр дүн, шинэ бүтээл, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэх;

3. Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилт (Matching fund) болон хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн татварын таатай орчинг бий болгох;

4. Хэрэглээний шинжлэх ухаан, хиймэл оюун, дижитал бизнес, ногоон технологи, гарааны бизнесийг дэмжих инновацийн хөрөнгө оруулалтын санг байгуулан ажиллуулах;

5. Дэлхийгээр тархан байгаа нарийн мэргэжлийн Монгол инженер, академик ажил эрхэлж буй эрдэмтэд, мэдлэг ур чадвар эзэмшиж буй Монгол оюутан нарын ур чадвар, хүний нөөцийн мэдээллийг бүрдүүлэх, тэдгээрийн мэдээлэлд суурилсан бодлогын чиглэлийг тогтоон “Гадагш урсах тархины урсгалыг эгүүлэн татах” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх;

6. Монгол улсын хөгжлийн асуудалд шийдвэрлэх үүрэг бүхий шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн салбар дундын (interdisciplinary) болон салбар дамнасан (transdisciplinary) үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төслийг хэрэгжүүлэх;

7. Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан батлуулж, шинжлэх ухааны паркийн техник, эдийн засгийн үндэслэл, бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийг төр хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх;

8. Цахим шилжилтийг эрчимжүүлж их өгөгдөл, хиймэл оюун, технологи мэдээлэлд суурилсан нээлттэй шинжлэх ухааны үйлчилгээг нэвтрүүлэх;

9. Их өгөгдөл, хиймэл оюун, супер компьютерын тооцоололд суурилсан виртуал/цахим шинжлэх ухааны паркийн хөгжүүлэх, инновац, гарааны бизнесийн үйл ажиллагааг эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс буюу шинжлэх ухаан, технологийг паркуудыг бүсчлэн хөгжүүлэх;

10. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор, технологи дамжуулах төв, салбар дундын нээлттэй лабораторийг байгуулан, шаардлагатай дэд бүтцийг бий болгох.

3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний өнөөгийн байдал:

"Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль", "Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол"-ын дагуу Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргаж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж журамд заасан хугацаанд Засгийн газарт хүргүүлж ажиллаж байна. Мөн Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал: Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль", Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу үндэсний хэмжээний урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг Улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган, Засгийн газар болон УИХ-д жилд 2 удаа хуулийн хугацаанд тайлагнадаг.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт ирүүлж буй төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдыг чадавхжуулах, сургалтад хамруулах, тогтвортой мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна. Мөн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналыг иж бүрэн хүлээн авч, үнэлгээ хийхэд нэн тэргүүнд программ хангамжийг боловсронгуй болгох, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хавсралт баримт бичиг болох Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт, тайлагналыг программаар хүлээн авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг байх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Тус нэгж нь Үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газарт хүргүүлэхээс гадна дотоод аудитын үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийж, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж ажиллах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд нэгжийн чиг үүргийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахын тулд хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгцээг

оновчтой зөв тодорхойлж, мэргэшсэн, чадварлаг албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, бүтэц, орон тоог нэмэгдүүлэх нь чухал байна.

Цаашдын зорилт: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь Улсын хэмжээнд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарч байгаа юм.

Иймд улсын хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлтэд үндэслэн бодлогын баримт бичиг боловсруулах, зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал боловсруулах, хэрэгжилтийг хүлээн авах программ хангамжийг боловсронгуй болгох нь зүйтэй байна.

Программ хангамжийг боловсронгуй болгосноор оновчтой санал санаачилга дэвшүүлэх, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх, үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн чанар сайжирч, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

3.6. Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны бодлогын өнөөгийн байдал:

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 11 сарын байдлаар 25.2 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар өссөн. Гадаад худалдааны тэнцэл 4.0 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өсөж 14.6 тэрбум ам.долларт хүрэхэд зэсийн баяжмалын экспорт 22 хувь буюу 528 сая ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 27 хувь буюу 181 сая ам.доллар, төмрийн хүдэр баяжмалын экспорт 39% буюу 154 сая ам.доллар, чулуун нүүрсний экспорт 2 хувь буюу 122 сая ам.доллароор өссөн нь голлон нөлөөлөв.

2023 оны эхний улиралд коксжих нүүрсний гадаад эрэлт тогтвортой байснаас гадна 2022 оны хоёрдугаар хагасаас эхлэн хилийн боомт дахь тээврийн саатап арилсан нь нүүрсний экспорт сэргэхэд нөлөөллөө. Мөн Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолоор ашигт малтмалыг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулж эхэлсэнтэй холбогдуулан нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой байлаа.

Мөн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль"-д орсон 10.3. "Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд худалдах гэрээг байгуулахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй" гэсэн өөрчлөлтийн дагуу Биржид бүртгэлтэй стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн

оролцоотой уул уурхайн бүтээгдэхүүн худалдагч компаниуд бүтээгдэхүүнээ оффтэйк гэрээгээр худалдах боломжтой болсон. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээрх үнийн бууралт манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа талаар дурдсан. Мөн түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, тус улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулахаар байна. Түүнчлэн, дэлхийн банкны "Түүхий эдийн зах зээлийн хэтийн төлөв"-т түүхий эдийн зах зээлийн голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ 2025 онд дунджаар 12.4 хувиар буурах талаар дурдсан. Иймд 2025 онд биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний үнэ 2024 оны биржийн арилжааны үнээс буурах төсөөлөлтэй байна.

Харин 2025 онд дээрх үнийн хүчин зүйлс болон спот, форвард зах зээл дэх нөхцөл байдал, худалдагч захиалгаа брокероор дамжуулан гүйцэтгүүлэх зэргээс шалтгаалан нийт 20 сая тонн нүүрсийг арилжаалах тооцоололтой байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өсөж 10.6 тэрбум ам долларын бараа, бүтээгдэхүүн худалдан авсан байна. Дээрх өсөлтийн 26.2 нэгж хувийг үнийн өөрчлөлт, 19.7 нэгж хувийг биет хэмжээний өөрчлөлт бүрдүүлжээ. 2024 оны эхний 11 сарын импортын үнийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж байсан дизель түлшний үнийн өсөлт тогтворжиж, нүүрсний экспорт нэмэгдэж байгаатай холбоотойгоор бие хэмжээний 23 хувийн өсөлт, үнийн дүнгийн 20 хувийн өсөлт нь импортын өсөлтөд голлох нөлөө үзүүллээ. Мөн уул уурхайн салбарын өсөлтийг дагаж ачаа тээврийн зориулалттай том машины импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тоо хэмжээний хувьд 42 хувь, үнийн дүнгийн хувьд 80% нэмэгдсэн байна. Энэ онд суудлын автомашины тоо импортын дүн 1.0 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 62 хувиар нэмэгдсэн байна. Улмаар автобензин импортын дүн 19 хувь нэмэгдсэн байна.

Үндэсний статистикийн хорооны өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2024 оны эхний хагас жилийн тайлан мэдээгээр өрхийн бодит орлого өмнөх оны мөн үеэс 17.3 хувь өссөн байгаа нь хүнсний бүтээгдэхүүний импорт нэмэгдэхэд бас нөлөөлсөн байна. Хүнсний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс үнийн дүн 23 хувь, биет хэмжээ 36 хувь өссөн нь тус тус шалтгаалсан байна.

Монгол Улс "Эдийн засгийн цогц байдлын индекс" буюу улс орны экспортод гаргаж буй бараа бүтээгдэхүүний нэр төрлөөр гаргадаг статистикт 133 орноос 118-д бичигдэж, сүүлийн 15 жилд 21 байр ухарчээ. Шинээр цайрын хүдэр, хар тугалганы хүдэр, лаазалсан мах, хадгалсан мах, тосны ургамлын үр (Рапс) болон ноосоор хийсэн нэхмэл даавуу гэсэн 6 төрлийн экспортын бүтээгдэхүүн нэмсэн байна.

2023 оны жилийн эцсээр түүхий эдээр гарч буй бүтээгдэхүүн нийт экспортын 91.8 хувь, хагас боловсруулсан ноос ноолуур, дулааны аргаар бэлдсэн мах, катодын зэс, арьс шир, жимс, самар зэрэг бүтээгдэхүүн нийт экспортын 5.6 хувь,

боловсруулсан бүтээгдэхүүний хувьд нэхмэл хувцас, лаазалсан мах, хивс зэрэг бага хэмжээний бүтээгдэхүүн багтдаг бөгөөд 1.6 хувийг л эзэлж байна.

Гадаад худалдааг хөнгөвчлөх, гадаад худалдааны үйл ажиллагааг хялбаршуулж, төрийн оролцоог бууруулах, ил тод болгох, экспорт, импортын санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэхтэй холбогдуулан Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолыг батлуулж, худалдааг хөнгөвчлөх асуудлаар холбогдох Засгийн газрын гишүүдэд арга хэмжээнүүдийг даалгасан болно.

Гадаад худалдааны таатай нөхцөл бүрдүүлж, экспортын зах зээлийн боломжийг тэлэх зорилгын хүрээнд Монгол Улс нь Ази Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орсноор БНСУ, БНЭУ, БНХАУ, Шри-Ланк, Бангладеш, Лаос руу ойролцоогоор 11 мянган төрлийн бараа бүтээгдэхүүнийг, Европын холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Систем GSP+ статустай болсноор Европын Холбооны гишүүн орнууд руу 7200 төрлийн бараа бүтээгдэхүүнийг, мөн Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулснаар тус улс руу 5700 төрлийн бараа бүтээгдэхүүнийг тарифын хөнгөлөлттэй нөхцөлөөр гаргах боломжтой болсон. Иймд зөвхөн Монголд хөрөнгө оруулахаас гадна түүхий эдийн нөөцийг нь ашиглан боловсруулж, үйлдвэрлээд, буцаагаад экспортлох боломжтой.

Үүнээс гадна экспортыг төрөлжүүлэх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, хоёр талт хамтын ажиллагааг иж бүрэн хөгжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахаар албан ёсны хэлэлцээг 2023 оноос эхлүүлж эхний шатны хэлэлцээг хийсэн бөгөөд 2024 онд гурван шатны хэлэлцээ, нийт дөрвөн шатны хэлэлцээг албан ёсоор зохион байгуулж, Монгол Улсын эрх ашгийг хамгаалах, гадаад таатай орчныг бий болгохоор чиглэлээр холбогдох яриа хэлэлцээг хийв.

Түүнчлэн, ОХУ-д Монгол Улсаас хөдөө аж ахуйн гаралтай цөөн нэр төрлийн барааг татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох мөн худалдаан дахь техникийн саад тотгорыг бууруулж, барааг саадгүй нэвтрүүлэх зорилгоор Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны түр хэлэлцээрийг байгуулахаар албан ёсны яриа хэлэлцээг хийж, барааны жагсаалт, хэлэлцээрийн төсөлд хэлэлцээг үргэлжлүүлж байна.

ЕАЭЗХ-ны хувьд хөдөө аж ахуй тэр дундаа малын гаралтай бүтээгдэхүүнд 15-50 хувийн гаалийн татвар ногдуулдаг бөгөөд бараа нэвтрүүлэхтэй холбоотой харьцангуй өндөр шалгуур, шаардлагыг тавьдаг. Тус хэлэлцээрээр Монгол Улс тус холбооны нийт 5 гишүүн орны зах зээлд саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.

Тулгамдаж буй асуудал: Гадаад худалдааны ашиг нь зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай, хэрэглээний бараанд импорт зонхилсон өнөөгийн нөхцөл байдалд хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөр зам, авто замын дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг одоогийн хэрэгжүүлж буй арга хэмжээнээс гадна экспорт, импортын үйл ажиллагааг цахимжуулах, түргэн шуурхай, зардал

багатай явуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, уул уурхайн болон уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг ахиулж, экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дэлхийн банкнаас 2020 онд хийсэн "Бизнес хийх орчны судалгаа"-ны "Хил дамнасан худалдаа" үзүүлэлтээр Монгол Улс 190 орноос 143 дугаар байранд оржээ. Энэ нь манай улсын гадаад худалдааны эрх зүйн зохицуулалт хангалтгүй, хяналт шалгалтын болон гаалийн байгууллагын уялдаа холбоо муу, хилийн хяналт, тээвэр, логистикийн хөгжил сул байгаагаас шалтгаалсан гэж дүгнэсэн байна.

Гадаад худалдаа эрхлэгчид экспорт хийхэд 16-аас дээш тооны баримт бичгийг бүрдүүлж, дунджаар 168 цаг зарцуулдаг бөгөөд нэг мэдээллийг дунджаар 12 удаа давхардуулан илгээдэг, зарим төрлийн мэдээллийг цахимаар илгээх боломжгүй байгаа зэрэг нь гадаад худалдаанд томоохон саад тотгор болж байна.

Гадаад худалдааны эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуулийн холбогдох заалт, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зэрэг хэд хэдэн хуульд суурилж байгаа нь бусад улс орны эрх зүйн зохицуулалтын түвшнээс хоцрохгүй байх, худалдааны салбарын хөгжилд урьдчилж зохицуулаагүй олон талын бэрхшээл үүсгэж байна.

Монгол Улсын экспорт, импортын бүтцийг харахад цөөн нэр төрлийн түүхий эдийн экспорт, уул уурхайн салбараас хэт хамааралтай байна. Монгол Улс дотооддоо цөөн нэр төрлийн бараа үйлдвэрлэж, техникийн болон хэрэглээний нэрийн барааг гаднаас авдаг тул дийлэнх орнуудтай хийсэн гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарч байна.

Мөн бүс нутаг, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байршил, зам тээврийн боломжийг зохистой ашиглаж, хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх шаардлагатай байгаа боловч бодит байдал дээр "Чөлөөт бүс"-д аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах орчин бүрдээгүй, хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө эрсдэлгүй өсгөх боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал, бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалт татах дэд бүтцийн болон хууль эрх зүйн таатай орчин, ашиг орлого олох нөхцөл бүрдээгүйн улмаас ажлын байрыг нэмэгдүүлж орон нутгийн хөгжилд томоохон ахиц дэвшил гарахгүй, эдийн засгийн үр өгөөжгүй байна.

Цаашдын зорилт: Цаашид гадаад худалдааны орчин, экспортын үйл ажиллагааг сайжруулж, худалдааг хөнгөвчлөх зорилгоор Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх, үүний хүрээнд гадаад худалдааны явцад бүрдүүлдэг баримт бичгийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа болон зардлыг бууруулах, экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг татварыг хувааж төлөх, хойшлуулах, экспортын бүтээгдэхүүнд шаардагдах импортын орц, завсрын бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх боломжийг бүрдүүлэх, Монгол Улсад нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ хэлэлцээрүүдийн хүрээнд экспортын зах зээлийн боломжийг бүрэн ашиглах, шинээр гэрээ хэлэлцээр байгуулж, таатай нөхцөлөөр экспорт хийх

боломж бүрдүүлэх, тухайн зах зээлд чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхтэй татах, нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

Тухайлбал, БНСУ-тай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болон ЕАЭЗХ-той байгуулах чөлөөт худалдааны хэлэлцээрийн хоёр талын албан ёсны яриа хэлэлцээ эхэлсэн, олон нийтийн оролцоо, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод хооронд олон нийтийн хэлэлцүүлгийг нээлттэй зохион байгуулж, хэлэлцээр байгуулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Мөн уул уурхайн экспортын боловсруулалтыг нэг шат ахиулах болон уул уурхайн бус бүх төрлийн бараа бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх, боловсруулах үйлдвэрлэлийг дэд бүтэц, санхүүгийн зөв схемээр дэмжих, үйлчилгээний экспортыг хөгжүүлэх зэрэг төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх худалдааны бүтцийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авч ажиллана.

3.7. Хөрөнгө оруулалтын бодлогын өнөөгийн байдал:

Монгол Улсад 1990 оноос 2024 оны III дугаар улирал хүртэл нийт 47.01 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 74 хувь нь уул уурхайн олборлолт, 10 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Оюутолгой төслийн уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор сүүлийн 10 жилийн дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 42 хувийг тус төсөл дангаар бүрдүүлж байна.

Статистик судалгаанаас харвал Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн 9 жилийн хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлттэй шууд хамааралтай бөгөөд 2023 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 17 хувийг эзэлж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1990-2023 онд нийт 14,836 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 5,486 аж ахуйн нэгж татан буугдсан бөгөөд эдгээрийн 33 хувь нь 2010-2022 онд татан буугдсан байна. Мөн сүүлийн 3 жилийн дунджаар аж ахуйн нэгжийн төлсөн нийт татварын 23 хувийг буюу 2.63 их наяд төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүрдүүлсэн бол 2022 онд 16 хувь буюу 2.4 их наяд төгрөг болж буурсан байна. Өөрөөр бол гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн 10 жилийн хугацаанд дорвитой өссөнгүй.

Манай орны ялгаруулж буй хүлэмжийн хий дэлхийн нийт ялгарлын 0.1 орчим хувь буюу маш бага хувийг эзэлж байгаа ч нэг хүнд ногдох хэмжээгээр дэлхийн дунджаас хэд дахин өндөр байна. Монгол Улс Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд үндэсний хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг суурь нөхцөлтэй харьцуулан 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах зорилт тавьсан. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс гаргасан судалгаагаар Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилт болон Засгийн газрын хүлээсэн бусад үүрэг амлалтыг

хэрэгжүүлэхэд манай улсын ногоон санхүүжилтийн хэрэгцээ жил бүр 1.0 тэрбум гаруй ам.доллараар хэмжигдэж байна.

Санхүүжилтийн хэрэгцээг тоймлон үзвэл ҮТХН-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд 11.5 тэрбум ам.доллар, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд 2030 он хүртэл нэмэлтээр 43 тэрбум ам.доллар шаардлагатай бол Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ногоон тодотголтой төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 20 гаруй их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах урьдчилсан тооцоолол гараад байна.

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд хамтран 2022 онд баталсан "Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг"-т 2030 он гэхэд ногоон зээлийн багцын нийт зээлд эзлэх хувийг 10 хувьд хүргэх зорилт тавьсан. Монголбанкны гаргасан мэдээллээр 2024 оны гуравдугаар улирлын байдлаар ногоон зээлийн эцсийн үлдэгдэл 1.18 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцын 3.4 хувийг ногоон зээл эзэлж байна.

Тулгамдаж буй асуудал: Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн санал хүсэлт болон байгууллагуудаас авсан судалгаанаас үзэхэд хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт хууль, эрх зүйн орчны тогтворгүй байдал, Монгол Улсын Засгийн газар болон холбогдох төрийн байгууллагууд гэрээний үүргээ хэрэгжүүлдэггүй, ил тод байдал хангалтгүй буюу авлига, хүнд суртал ихтэй, хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоо хангалтгүй, аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зэрэг асуудлууд байна.

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчийг зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үеийн бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтын үе шатад тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Ногоон санхүүжилтийг дэмжих бодлого, эрх зүйн орчин хангалтгүй, төр, хувийн хэвшлийн байгууллагын чадавх сул, ногоон санхүүжилтийн хүртээмж хангалтгүй, байгальд ээлтэй, ногоон төслүүдийг хэрэгжүүлэх чадвар бүхий боловсон хүчин дутагдалтай байгаагаас гадна нэг салбараас хэт хамааралтай эдийн засгийн сул тал зэрэг асуудлууд ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, санхүүжилт татах арга хэмжээг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж болзошгүй байна.

Цаашдын зорилт: Монгол Улсын хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлж, хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчийг зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үеийн бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтын үе шатад

тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллана.

Үндэсний хэмжээний ногоон санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дунд, урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн ногоон төслүүдийг тодорхойлж, санхүүжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлнэ.

3.8. Хөгжлийн төслийн бодлогын өнөөгийн байдал:

Монгол Улсын эдийн засаг дан ганц анхдагч цөөн төрлийн түүхий эдийн олборлолт, түүний экспортод суурилсан хэвээр байна. Өөрөөр хэлбэл, нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт, жонш зэрэг нэмүү өртөг шингээгүй түүхий эдийн экспортын орлогоос эдийн засаг ихээхэн хамаарч байна. Ашигт малтмалын түүхий эдийн экспорт нийт экспортын 90 гаруй хувийг бүрдүүлж байгаа нь манай улс нэмүү өртөг шингээгүй, гадаад зах зээлийн үнэ ханш болон Хятад улсын эдийн засгаас шууд хамаарсан сул эдийн засагтай хэвээр байна. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өсгөх болон нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтыг үе үеийн Засгийн газар дэвшүүлж ирсэн боловч дорвитой дэвшил гарахгүй байна. Өөрөөр хэлбэл, нэмүү өртөг шингээх болон эрчим хүч, дэд бүтцийн төслүүд, экспортыг нэмэгдүүлэх төмөр зам, авто замын томоохон мега төслүүдийн хэрэгжилт удаашралтай, гацсаар олон жил болж байна. Тухайлбал, хил холболтын төмөр замын төслүүд, Тавантолгой цахилгаан станц, Эгийн голын усан цахилгаан станц, зэс, гангийн үйлдвэрийн төслүүдийг барих зорилтыг Засгийн газар тавьж ирсэн ч өнөөг хүртэл хэрэгжиж эхлээгүй л байна. Энэ нь доор тулгамдсан асуудал хэсэгт дурдсан асуудлуудтай шууд холбоотой юм.

Узбекистаны Самарканд хотод 2022 онд болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын ээлжит уулзалтын үеэр Монгол, Орос, Хятадын төрийн тэргүүн нарын зургаадугаар уулзалтаар талууд Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг дахин 5 жилээр сунгахаар шийдвэрлэснийг баталгаажуулсан бөгөөд Москва хотноо 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хуралдсан Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудлаарх ажлын хэсгийн 6 дугаар хуралдааны үеэр Монгол болон Хятад улсын талууд Хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулах асуудлыг судлахыг санал болгосны дагуу гурван тал энэ асуудлаар 2023 оны 10 дугаар сараас эхлэн санал солилцон жагсаалтыг шинэчилж, 2024 оны 9 дүгээр сар гэхэд 33 төсөл, арга хэмжээг эцэслэн тохирсныг 2024 оны 10-11 дүгээр сард гурван улсын хариуцсан байгууллагуудын тэргүүн нар харилцан захидал солилцож албажуулан баталгаажуулсан.

Тус шинэчилсэн жагсаалтад зам, тээврийн салбарын 11, худалдааг дэмжих чиглэлээр 6, ногоон хөгжлийн 3, шинжлэх ухаан, техник, боловсролын салбарын 4, эрүүл мэндийн 2 болон аж үйлдвэр, эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарын тус тус 1

арга хэмжээнүүд, ач холбогдолтой гэж үзсэн бусад 4 ажил, арга хэмжээнүүд багтсан.

Эдгээр төсөл, арга хэмжээний нэгдүгээрт эрэмбэлэгдсэн "Төмөр замын төв коридорыг иж бүрэн шинэчлэн хөгжүүлэх, хос зам барих, цахилгаанжуулах боломжийг судлах" төслийг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/144 дугаар тушаалаар Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх ТЭЗҮ-г судлах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэ асуудлаарх гурван улсын Хамтарсан ажлын хэсгийн хуралдааныг ОХУ-ын Москва хотноо 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдөр, хоёрдугаар хуралдааныг БНХАУ-ын Тяньжин хотноо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр, гуравдугаар хуралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд Монгол Улсын Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулсан.

Ажлын хэсгийн гуравдугаар хуралдааны протоколоор гадаад худалдааны ачаа тээврийн тоо хэмжээний таамаглалыг 2025-2050 онуудаар, ТЭЗҮ боловсруулах нэгдсэн төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах Техникийн ерөнхий даалгаврыг тус тус батлуулсан ба тус протоколын дагуу "УБТЗ" ХНН дээр "Төслийн нэгж" байгуулан ажиллаж байна. Эдийн засгийн коридорын Төмөр замын төв коридорын монголын талын /Сүхбаатар-Замын-Үүд/ ТЭЗҮ боловсруулах ажлын явц 90 хувийн гүйцэтгэлтэй, эцсийн тайланг 2024 оны 9 дүгээр сард багтаан ЗТЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, мөн энэ оны 4 дүгээр улиралд багтаан Орос, БНХАУ-ын талуудтай ТЭЗҮ-г нэгтгэх ажлыг хийхээр төлөвлөсөн.

Эдийн засгийн коридорын хөтөлбөрт туссан бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээллийг холбогдох яамдаас авч нэгтгэж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрчимжүүлэх талаар төсөл, арга хэмжээг хариуцсан байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн хэрэгжилтийн асуудал хариуцсан Үндэсний ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 123 дугаар захирамжаар шинэчлэн байгуулаад байна.

Тулгамдсан асуудал: Мега төслүүдийн хэрэгжилт удаан байх, гацах олон шалтгаан байгааг төсөл хэрэгжүүлэгч талууд болох яамд, төслийн нэгжүүд дурддаг. Тухайлбал, мега төслүүдийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчин хангалттай бүрдэж чадаагүй байна. Үүнд хөрөнгө оруулалт болон ашигт малтмал, газрын тухай, гааль, татвар, тарифтай холбоотой хуулиуд, худалдан авалт, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэх мэт хууль эрхзүйн орчин сул хэвээр байна. Мөн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөлт, хэрэгжилтэд тавих олон улсын жишигт хүрсэн хяналт, мониторингийн систем манай улсад бүрдээгүй байна. Иймд хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, түүнд тавих хяналт сул байгаа нь мега төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд саад, бэрхшээл болж байна. Түүнчлэн, мега төслүүдийн хэрэгжилтийн төлөвлөгөө, үнэлгээний талаарх

нэгдсэн мэдээллийн систем байхгүй, мэдээллийн тогтмол урсгалыг бий болгох, мэдээлэх, түүнд хяналт тавих журам, зохицуулалт, систем байхгүй байна.

“Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн төсөл, арга хэмжээнүүд нь гурван улсын ашиг сонирхлыг нийцүүлж, бүс нутгийн болон олон улсын интеграцид зохистойгоор нэгдэхэд хамтран ажиллах зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг нь геополитикийн өнөөгийн ба хэтийн нөхцөл байдал, үйл явдал хэрхэн өрнөхөөс шалтгаалан зарим тохиолдолд төсөл, арга хэмжээ биднээс хамаарахгүйгээр хэрэгжихгүй байх, удаашрах хүндрэл, эрсдэлүүд гарах магадлалтай. Мөн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлтүүд тодорхойгүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх хамтын механизм байгуулах тухай харилцан тохирсон ч энэ чиглэлд хийгдсэн дорвитой зүйл байхгүй зэрэг хүндрэлүүд байгааг уг хөтөлбөрийн өмнөх 5 жилээр төлөвлөж байсан ажлуудын хэрэгжилтээс харж болохоор байна.

Цаашдын зорилт: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт салбаруудын шинэчлэлийн хүрээнд 14 мега төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлснээр экспортын орлого 2-4 дахин нэмэгдэх, эдийн засгийн өсөлт 6-8 хувьд хүрч ирэх 4 жилд Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 10,000 ам.долларт хүрч иргэдийн амьжиргааны чадвар эрс дээшилнэ.

Бэрхшээлүүдийг шийдвэрлэх зорилгоор эхний ээлжид Мега төслүүдийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчны бүрэн шинжилгээг хийх, холбогдох хууль, журмуудад өөрчлөлт оруулах, мөн мега төслүүдийн хэрэгжилтийн төлөвлөгөөний биелэлтэд тогтмол хяналт, шинжилгээ, үнэлгээг хийх мониторингийн системийг хөгжүүлж, Засгийн газар дээр хэрэгжилтийг тогтмол хэлэлцдэг, шаардлагатай бодлогын арга хэмжээг тухай бүр авч ажилладаг тогтолцоог бий болгох зорилтыг тавьж ажиллана.

“Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн шинэчилсэн жагсаалтад орсон төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх ажлыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулж эрчимжүүлэх, Үндэсний ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулж дотоодын холбогдох байгууллагуудыг удирдлагаар хангах, Эдийн засгийн коридорын хөтөлбөрийн асуудал хариуцсан Монгол, Орос, Хятадын байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэн гурван улсын Хамтарсан ажлын хэсгийн уулзалт, хуралдааныг зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

3.9. Салбаруудын шинэчлэлийн өнөөгийн байдал:

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.1.5-д Бизнесийн таатай орчин бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадвар дээшилсэн байна, Зорилт 4.1.6-д Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Зах зээл дэх

төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ” гэж тус тус заасан.

Хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийг дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд Монгол Улсын Эдийн засгийн нэн тэргүүний зорилго хэвээр байна.

Монгол Улсад 2024 оны III улирлын байдлаар 90,131 компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 77,229 буюу 85.7 хувь нь 1-9 хүртэлх ажиллагчтай буюу "бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" ангилалд багтаж байна. Бизнес эрхлэгчдийн дийлэнх нь "бичил" ангилалд буй нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд эдгээр бичил бизнесүүдийг чадавхжуулах шаардлага байсаар байгааг илтгэж байна. Түүнчлэн МҮХАҮТ-ын "Монголын бизнесийн орчин-2023" судалгааны үр дүнгээс харахад 2023 оны Бизнесийн орчинд бизнес эрхлэгчид 2.68 гэсэн үнэлгээ (5 онооноос) өгсөн ба үнэлгээг цар тахлын өмнөх 2020 онтой харьцуулбал 0.23 нэгжээр буурсан дүн байна. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчид цар тахлын өмнөх үетэй харьцуулахад бизнесийн орчин муудсан гэж үзжээ.

Иймд бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, татварын орчин, түүнтэй холбоотой хүндрэлүүд, жижиг, дунд бизнесүүд болон томоохон ААНБ-д тулгамдаж, өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлж буй асуудал болон өнөөгийн байдлаар авч хэрэгжүүлсэн санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийн үр нөлөө, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний оновчлолыг сайжруулах шаардлага үүсэж байна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах, бизнесийн орчныг сайжруулах, бизнесийн тогтвортой өсөлтийг хангахын тулд бодлогын оновчтой шийдэл, зөв хувилбар боловсруулж хэрэгжүүлэх нь чухал юм. Харин үүний тулд бодитой өгөгдөл, судалгааны мэдээлэл шаардлагатай. Учир нь бизнес эрхлэгчдэд учрах хүндрэл, бодлогын нөлөөллийг судалсан гүнзгийрүүлсэн судалгаа хомс байна.

Монгол Улс зах зээлд суурилсан эдийн засагт шилжээд 30 гаруй жил болж байгаа ч эдийн засгийн зарим салбарт төр засгийн зохицуулалт өндөр, төрийн өмчит ААНБ-ын тоо, цар хүрээ их байна. Тухайлбал, 2024 оны 3-р улирлын байдлаар эдийн засгийн үйл ажиллагааны салбарт нийтдээ 469 төрийн болон орон нутгийн өмчит ААН үйл ажиллагаа явуулж байна.

2024 оны 3-р улирлын байдлаар нийт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ийн 5.5 хувь нь төсвийн болон Төрийн өмчийн үйлдвэрийн газар болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар үлдсэн 94.5 хувь нь компани, төрийн бус байгууллага, хоршоо, нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 99,190 байгууллагын (төсвийн болон Төрийн өмчийн үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар хассан) ААНБ-ын ихэнх нь буюу 41 хувь нь Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 8 хувь нь барилгын салбарт, 7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 86 хувь нь 1-9

ажилтантай, ердөө 3 хувь нь 50-с дээш тооны ажилчидтай байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нийт 76,561 хуулийн этгээдийн 77 хувь нь жилийн борлуулалтын орлого 300.0 сая төгрөг хүртэл байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын ДНБ-д хувийн хэвшлийн ААНБ-ын оруулж буй хувь нэмэр 2000-2010 оны хооронд 72 хувь 2011-2020 оны хооронд 77 хувийг бүрдүүлсэн бол 2021 онд 76.2 хувь, 2022 онд 77 хувь, 2023 оны хооронд 75.3 хувьтай байсан ба нийт эдийн засагт хувийн хэвшлийн оролцоо өндөр байгааг харуулж байна. Мөн 2023 оны байдлаар Монгол Улсад нийт 1,294,746 ажиллагчид байгаагийн 82.5 хувь буюу 1,068,250 нь хувийн хэвшилд ажиллаж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар /цаашид НӨАТ гэх/ нь үйлдвэрлэгч болон худалдаачдаас авч буй татвар биш эцсийн хэрэглэгчдээс авдаг бараа, ажил үйлчилгээнд ногддог татвар байна. Гэтэл уг зорилгыг хэрэгжүүлэх үүрэгтэй НӨАТ нь дараах хүндрэл, тогтолцооны гажуудлыг үүсгэж байна^[1]

- Импортоор оруулж буй бараанд нэмүү өртөг үүсгээгүй байхад НӨАТ-ыг гаалийн бүрдүүлэлт хийхэд урьдчилж төлөх нь НӨАТ төлөгч компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд хүндрэл учруулдаг, төдий чинээ эдийн засгийн өсөлтийг нь хязгаарладаг.
- Татвараас зайлсхийх, зугтаах боломжтой, бүртгүүлбэл зохих этгээдийг бүрэн хамруулж чадахгүйгээс ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг боловч НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлдөг (Монгол улсад нийт 187 мянган ААН бүртгэлтэй байгаагаас зөвхөн 37 мянга нь НӨАТ төлөгч байна).
- Борлуулалтад ногдох НӨАТ-ыг аккрузал сууриар тооцож ногдуулдаг нь мөнгө хараахан орж ирээгүй борлуулалтын татварыг хүүтэй зээлээр төлөх дарамт үүсдэг.
- Худалдан авалтад ногдох НӨАТ-ыг мөнгөн сууриар тооцож ногдуулдаг нь НББ-ийн стандартаас зөрүүтэйгээр худалдан авалтыг татварт тайлагнах, тооцоолол, тайлагналд хүндрэл учруулж санхүүгийн тайлан, татварын тайлангийн зөрүү гаргах, улмаар хүндрэлтэй эдгээр тооцоололд татварын мэргэшсэн нягтлан бодогчийг хөлслөх зардал нэмэгдүүлдэг.
- Эдийн засгийн үргүй зардал, эргэлтийн хөрөнгийн хомсдол нь аж ахуй нэгжийг хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүйд хүргэж, ихэнх бизнесийн байгууллагууд НӨАТ-с зайлсхийх зорилгоор 2 касстай болсон.
- ААН-үүд, татвар, бусад төр захиргааны байгууллагуудад татварын хяналтыг хэрэгжүүлэх давхар давхар орон тооны зардал, холбогдох бусад үйл ажиллагааны зардал нь Монгол улсын нүдээр үргүй зардлыг нэмэгдүүлдэг.
- Бизнесийн байгууллагууд үнэн зөвөөр татварын орлогоо тайлагнадаггүй учраас талон бүр е-баримтын бүртгэлд хамрагддаггүй^[2].

^[1] НӨАТ-г худалдааны татвар болгон хувь хэмжээг 3 хувь болгосноор бүх бүртгэлтэй ААН татвар төлөх боломжийг тэгш, ялгаваргүйгээр олгож, татварын бааз суурь 5 дахин нэмэгдэх боломжтой. Жишээ нь НӨАТ-ын орлого 2002-2006 онд өмнөх оноос дунджаар 16.8 хувь өсдөг байсан бол 2007 онд НӨАТ-г 15 хувь байсныг 10 хувь болгосноор 38.9 хувь болж өссөн.

^[2] 2023 оны эцсийн байдлаар 250 мянга орчим аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байгаагаас 50 гаруй мянга буюу нийт 20% орчим нь НӨАТ төлөгч байна. Харин татварын хэмжээ 10% байгааг 3% болгосноор татвар төлөгчдийн тоо 5 дахин өсөж татварын бааз суурь нэмэгдэхээр байна. Өнөөдрийн байдлаар Нарантуул, Хархорин, Дүнжингарав, Бөмбөгөр, Зуун айлын гудамж гэх мэт нийслэл, орон нутгийн томоохон хүнсний бөөний захууд, 3,4-р хороолол дахь жижиглэн худалдаачид, ченжүүд, үйлчилгээний цэгүүд НӨАТ-н системд бүрэн хамрагдаагүй, НӨАТ-ын баримт хэвлэж, худалдан авагчид олгодоггүй хэвээр байна.

Тулгамдсан асуудал: Дэлхийн банкны Бизнес эрхлэхүй судалгаа нь 2003 онд анх 133 орны харьцуулж эхэлсэн бол энэ тоо нь 190 болж өссөн билээ. 2020 онд хамгийн сүүлийн тайлангаа боловсруулж олон нийтийн хүртээл болгосон. Аргачлалын хувьд 10 бүлгээр авч үздэг байсан: (I) Шинээр бизнес эрхлүүлэх-үүнд шинээр ААН бүртгүүлэхэд зарцуулж буй хугацаа, зардал болон үүсгэн байгуулах үндсэн хөрөнгө. (II) Барилгын зөвшөөрөл авах-тусгай зөвшөөрлөө авахад шаардлагатай алхмууд, хугацаа, зардал; (III) Эрчим хүчинд-эрчим хүчинд холбогдоход шаардлагатай алхам, хугацаа, зардал; (IV) Үл хөдлөх хөрөнгөө бүртгүүлэх-үл хөдлөхөө бүртгүүлэхэд шаардлагатай алхам, хугацаа, зардал; (V) Зээл авах-зээлийн мэдээллийн тогтолцооны давуу тал, зээлдэгч, зээлдүүлэгчийн эрх зүйн хамгаалалт; (VI) Жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах-(VII) Татвар төлөлт-татвараа төлөхөд шаардлагатай хугацаа мөн зардал, татваруудын тоо; (VIII) Хил дамнасан худалдаа-бараа бүтээгдэхүүн экспортлоход шаардлагатай хугацаа ба зардал; (IX) Гэрээний хэрэгжилтийг хангах-арилжааны маргааныг шүүхээр шийдвэрлэх хугацаа, зардал; (X) Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх-төлбөрийн чадваргүйдлийг шийдэхэд шаардлагатай хугацаа, зардал, нөхөн төлбөр.

“Бизнес эрхлэхүй 2020”-д Монгол Улс 190 орноос 81-т эрэмбэлэгдсэнээр өмнөх оныхоос долоон байр ухарлаа. Бизнес эрхлэхүй судалгаагаар Монгол Улс олон жил дараах 3 үзүүлэлтүүдээр доогуур эрэмбэлэгдэж байсан бөгөөд өнөөдөр болтол эдгээр хүндрэлтэй асуудлууд шийдэгдээгүй хэвээр байна. Үүнд:

Хүснэгт 4. Бизнес эрхлэхүй судалгаагаар Монгол Улсын муу үзүүлэлтүүд

Дэд үзүүлэлт	Сорилт	Үзүүлж буй нөлөө
Эрчим хүчинд холбогдох	-Цахилгаан, эрчим хүчинд холбогдоход маш удаан үйл ажиллагаа -Орлогын түвшинтэй харьцуулахад өндөр холболтын зардал -Нийтийн үйлчилгээ болон дэд бүтцийн үр ашиггүй байдал	-Үйл ажиллагаа эхлүүлэхэд удаашруулдаг -Жижиг дунд үйлдвэр хувьд хэтэрхий өндөр зардал
Төлбөрийн чадваргүйдлийг шийдэх	-Үйл ажиллагаа нь сэргээгдэж байгаа ААН тоо бага -Төлбөрийн чадваргүйдлийг зохицуулах хууль дүрэм журам нь үр ашиггүй	Бизнес эрхлэгчид өр барагдуулах эсвэл санхүүгийн хүндрэлийг үр дүнтэй шийдвэрлэх эсэх нь эргэлзээлтэй тулгардаг тул хөрөнгө оруулагчид болон зээлдүүлэгчдэд саад болдог.
Хил дамнасан худалдаа	Гаалийн үр ашиггүй үйл ажиллагаа, дэд бүтцийн сул хөгжил болон өртөг зардал ихтэй байдал нь олон улсын худалдаанд саад тотгор учруулдаг	-Олон улсын зах зээлд гарах боломжийг хязгаарладаг -Бизнесийн үйл ажиллагааг илүү зардалтай болгодог

Эх үүсвэр: Дэлхийн банкны Бизнес эрхлэхүй судалгаанаас хураангуйлав.

Хүснэгт 5. Бизнес эрхлэхүй судалгааны дэд бүлгүүд дэх Монгол Улсын эрэмбэ болон оноо

Бизнес эхлүүлэх (rank)	100	Зээл авах (rank)	25	Хилийн чанадаас худалдаа хийх (rank)	143
Бизнес эхлүүлэх оноо (0-100)	86.7	Зээл авах оноо (0-100)	80	Хилийн чанадаас худалдаа хийх оноо (0-100)	60.8
Журам (тоо)	8	Хууль эрх зүйн эрхийн индекс (0-12)	9	Экспортлох хугацаа	
Хугацаа (өдөр)	12	Зээлийн мэдээллийн индексийн гүнзгийрэл (0-8)	8	Баримт бичгийн бүрдүүлэлт (цаг)	168
Зардал (%)	1.2	Зээлийн бүртгэлийн хамрах хүрээ (насанд хүрэгчдийн %)	53.6	Хил дээрх ажиллагаа (цаг)	134
Төлсөн хамгийн бага хөрөнгө (нийт орлогын хувь)	0	Зээлийн товчооны хамрах хүрээ (насанд хүрэгчдийн %)	0	Экспортлох зардал	
Барилгын зөвшөөрөл авах (rank)	29	Цөөнхийн эрх ашгийг хамгаалах (rank)	25	Баримт бичгийн бүрдүүлэлт (ам.доллар)	64
Барилгын зөвшөөрөл авах оноо (0-100)	78.2	Цөөнхийн эрх ашгийг хамгаалах оноо (0-100)	74	Хил дээрх ажиллагаа (ам.доллар)	225
Журам (тоо)	17	Мэдээллийг ил тод болгох индекс (0-10)	6	Импортлох хугацаа	
Хугацаа (өдөр)	137	Захирлын хариуцлагын индекс (0-10)	8	Баримт бичгийн бүрдүүлэлт (цаг)	115
Зардал (агуулахын үнэлгээний %)	0.1	Хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэх оруулга хялбаршуулах индекс (0-10)	8	Хил дээрх ажиллагаа (цаг)	48
Барилгын чанарын хяналтын индекс (0-15)	14	Хувьцаа эзэмшигчдийн эрхийн индекс (0-6)	2	Импортлох зардал	
Цахилгаан авах (rank)	152	Өмчлөл ба хяналтын индекс (0-7)	6	Баримт бичгийн бүрдүүлэлт (ам.доллар)	83
Цахилгаан авах оноо (0-100)	55	Корпорацын ил тод байдлын индекс (0-7)	7	Хил дээрх ажиллагаа (ам.доллар)	210
Журам (тоо)	8	Татвар төлөх (rank)	71	Гэрээний биелэлтийг хангах (rank)	75
Хугацаа (өдөр)	79	Татвар төлөх оноо (0-100)	77.3	Гэрээний биелэлтийг хангах оноо (0-100)	61.4
Зардал (нийт орлогын %)	603.5	Төлбөрийн тоо (жилийн)	19	Хугацаа (өдөр)	374

Нийлүүлэлтийн найдвартай байдал ба тарифын ил тод байдлын индекс (0-8)	3	Хугацаа (жилийн цаг)	134	Зардал (нэхэмжлэлийн үнийн %)	22.9
Үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх (rank)	50	Нийт татвар, шимтгэлийн хувь (% ашгаас)	25.7	Шүүхийн үйл ажиллагааны чанарын индекс (0-18)	5.5
Үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэх оноо (0-100)	74.2	Нөхөн мэдүүлэх индекс (0-100)	49.1	Дампуурлыг шийдвэрлэх (rank)	150
Журам (тоо)	5			Дампуурлыг шийдвэрлэх оноо (0-100)	30.1
Хугацаа (өдөр)	10.5			Сэргээх хувь (1 ам.долларт)	18.2
Зардал (үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний %)	2.1			Хугацаа (жил)	4
Газрын бүртгэлийн чанарын индекс (0-30)	14.5			Зардал (өмч хөрөнгийн %)	15
				Үр дүн (0 бол хэсэгчлэн зарах, 1 бол хэвийн үргэлжлэх)	0
				Дампуурлын зохицуулалтын индекс (0-16)	60.5

Эх үүсвэр: Бизнес эрхлэхүй судалгаа 2020, Дэлхийн банк

Цаашдын зорилт: “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус тусгагдсан Бизнесийн орчныг либералчлах, Жижиг дунд үйлдвэр болон гарааны бизнесийг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах замаар бизнес эрхлэгч, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагч нарт таатай, тогтвортой эдийн засгийн болон эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Дэлхийн банкнаас хэрэгжүүлдэг “Be-ready” бизнес эрхлэх орчны таатай байдлыг үнэлдэг олон улсын индикаторын үзүүлэлтийг ахиулан ирэх 4 жилд Монгол улсын ДНБ-ний нэг хүнд ноогдох хэмжээг 10,000 ам.доллар болгох зорилтод хүрнэ.

Мөн банк санхүү, даатгалын системийн эрх зүйн орчныг шинэчлэн өөрчлөх, сайжруулах замаар төрийн худалдан авалтыг давхар даатгалын системд хамруулж төрийн урсгал зардлыг багасгаж, төрийн үйлчилгээ, худалдан авалтыг өгөөжийг нэмэгдүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэл дээр тулгуурласан төрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Томоохон бизнесийнхэн болон Жижиг дунд үйлдвэр эрхлэгчидтэй хийсэн уулзалтын үр дүнгээс харахад төрийн байгууллагуудын уялдаа холбоо дутмаг, чиг үүргүүдийн давхцал ихтэй байгаа нь бизнес эрхлэхэд хүндрэл учруулсаар байна гэв. Мөн бизнестэй холбоотой татварын орчныг сайжруулж, бизнесийн таатай орчныг бий болгох чиглэлд буюу торгох биш дэмждэг хуулиуд батлахыг дурдаж байна. Татвартай холбоотойгоор Гаалийн албан татвар, ААНОАТ-ийн хөнгөлөлт, НДШ-ийн зохицуулалтууд хийх, НӨАТ-ийн өр ихээр үүсдэг ба зардлыг

баталгаажуулах баримтын систем учир дутагдалтай байдлыг сайжруулах эрх зүйн орчин болон бодлогын баримтыг боловсруулан өргөн барихаар төлөвлөж байна.

Аж үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох замаар Бүсчилсэн хөгжлийн бодлого, 14 МЕГА төсөл, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бүтээн байгуулалт, үйлдвэржүүлэлтийн төслүүдийг байгалийн болон хүний нөөц, дэд бүтэц, тээвэр, худалдааны боломжийг харгалзан оновчтой зохион байгуулах, байршуулах ажлыг зохион байгуулж ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 6. Орчны шинжилгээ

Дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсанаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай, нэгдсэн зохион байгуулалттай, нарийн төлөвлөгөөтэй, системтэйгээр хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн. 2.Үндэсний хөгжлийн хүрээлэнг байгуулснаар эдийн засаг, нийгмийг хөгжлийг шинжлэх ухааны үндэслэл, нотолгоонд суурилсан судалгааны ажлууд хийгдэж, эдийн засгийн өсөлтөд нөлөөлнө. 3.Шинжлэх ухаан технологийн салбар шилжин ирснээр Монгол Улсын үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн 2/-т “Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” гэж заасан хуулийн зохицуулалт бүрэн хэрэгжих нөхцөл хангагдах давуу талтай. Ө/х: “шинжлэх ухааныг эдийн засагжуулах, эдийн засгийг шинжлэх ухаажуулах” концепц бүрэн утгаараа хэрэгжих нөхцөл бүрдэж байна. Ингэснээр судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, улмаар уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.	1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн судалгааны байгууллагын гаргасан судалгаа, шинжилгээ дээр үндэслэн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг зөв оновчтой тодорхойлох эрх зүйн орчин бүрдсэн. 2. Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжийн албан хаагчдын тухайн чиглэлээр мэргэшсэн байдал дутмаг байгаа нь чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлийг бий болгож байна. Төрийн захиргааны байгууллагын цалин, урамшууллын өнөөгийн нөхцөлтэй холбоотойгоор албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах байдал хангалтгүй байна. 3. Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалсан салбарын бодлогын залгамж чанар алдагдаж байна. 4. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орж Хөгжлийн бодлогын баримт бичгийн хяналт тавих чиг үүрэг ЗГХЭГ, ХХГ-т шилжсэн бөгөөд тодорхойгүй байдал үүсэж, давхардал бий болсон нь сөрөг талтай. 5.Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-ийн 20/-д: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд “өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцооны бодлого, төлөвлөлт, хөгжүүлэх асуудал”-ыг бүхэлд нь хариуцуулахаар тогтоосон. Гэхдээ Засгийн газрын 2024 оны “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 06 дугаар тогтоолын 3-т: “Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газар, 2 хэлтэстэй, үүний дотор “Технологи, инновацийн шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтэстэй” байхаар заасан нь дээрх хуулиар олгосон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын чиг үүргийн эрх олгосон заалтыг зөрчиж байна. Нөгөө талаас хуулиар олгосон чиг үүргийг Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй чиг үүргээр Шинжлэх ухаан,

	технологийн нэгдсэн бодлогын газарт шинэ бүтцийн нэгж байгуулсан нь дээрх хуулийн заалтыг зөрчихөөс гадна яамд хоорондын чиг үүргийн давхардал үүсгэсэн байгаа нь инновацын бодлого, хэрэгжилт, зохицуулалт бүрэн хангагдах нөхцөлийг хязгаарлах сөрөг талтай.
Гадаад орчны шинжилгээ	
Боломж	Эрсдэл
1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус баталсантай холбогдуулан бодлого, төлөвлөлтийн нэгдсэн цогц арга хэмжээ авч, судалгаа шинжилгээний ажилд эрдэмтэн судлаачид, иргэд, хуулийн этгээдүүдийг оролцуулах замаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх боломж бий болсон. 2. Дээр дурдсан давуу тал хангагдахаас гадна Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.7.1.1 дэх заалтад зааснаар шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, тэргүүлэх чиглэлийг тогтоож, дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хүртэлх хувийг шинжлэх ухааны арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулах боломжийг бүрдүүлж байна.	1. Яамны чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчдын мэргэшсэн байдал хангалтгүй байгаагаас шалтгаалан Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. 2. Төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоо хангалтгүй, улсын хэмжээний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах мэдээллийн нэгдсэн сан бий болоогүйгээс хэрэгжилтийн зорилт, арга хэмжээ бүрэн тайлагнах боломжгүй байх эрсдэлтэй. 3. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орж Хөгжлийн бодлогын баримт бичигт хяналт хийх чиг үүрэг ЗГХЭГ-ын Хяналт хэрэгжүүлэх газар, ЭЗХЯ-ны чиг үүрэг давхардал үүсэж байгаа нь эрсдэлтэй байна. 4. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-ийн 20/-д: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд “өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны бодлого, төлөвлөлт, хөгжүүлэх асуудал”-ыг бүхэлд нь хариуцуулахаар тогтоосон. Гэхдээ Засгийн газрын 2024 оны “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 06 дугаар тогтоолын 3-т: “Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газар, 2 хэлтэстэй, үүний дотор “Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтэстэй” байхаар заасан нь дээрх хуулиар олгосон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын чиг үүргийн эрх олгосон заалтыг зөрчиж байна. Нөгөө талаас хуулиар олгосон чиг үүргийг Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй чиг үүргээр Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газарт шинэ бүтцийн нэгж байгуулсан нь дээрх хуулийн заалтыг зөрчихөөс гадна яамд хоорондын чиг үүргийн давхардал үүсгэсэн байгаа нь инновацын бодлого, хэрэгжилт, зохицуулалт бүрэн хангагдах нөхцөлийг хязгаарлах эрсдэл үүсгэж байна.

Хүснэгт 7. Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин			
			2025	2026	2027	2028	
1.	Эдийн засгийн өсөлт	хувь	6.0	8.0	6.5	6.5	
2.	Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт	хувь	8.0	7	5.0	5.0	
3.	Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.9	5	6	8	
4.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг	Баримт бичгийн тоо	3	4	1	1	
5.	Дэлхийн инновацын индекс	Байр/оноо	67	65	62	58	

Хүснэгт 8. "Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 он)	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум ам. доллар	13.1	23.9	Оны үнээрх ДНБ	Жилд нэг удаа
2	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7.2	6	-	Жилд нэг удаа
3	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	ам. доллар	4,009	6,520	Оны илэрхийлсэн үнээр	Жилд нэг удаа
4	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	24.3	30.6	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Жилд нэг удаа
5	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	10.9	12	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Жилд нэг удаа
6	Тээвэр агуулахын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	4.6	5.1	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Жилд нэг удаа
7	Экспорт	сая ам. доллар	7,011.8	14,020	Дотоодын үйлдвэрлэл сайжирснаар бүтээгдэхүүн экспортолж эхэлнэ.	Жилд нэг удаа
8	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	сая.хүн	0.6	1	Аялал жуулчлалын салбарын хөгжлийг Монгол Улсад ирж байгаа жуулчдын тоогоор хэмжинэ.	Жилд нэг удаа

Хүснэгт 9. Оролцогчдын шинжилгээ

д/д	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Хэрэгжих хугацаа	
1	УИХ, ЗГ, ЗГХЭГ, яамд, төрийн захиргааны төв байгууллагууд болон төрийн бусад байгууллагууд	Монгол Улсын үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн акт	2025	2028

Хүснэгт 10. Нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажилласан байдал

д/д	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Хэрэгжих хугацаа	
1	21 аймгийн Засаг дарга	Монгол Улсын үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн акт	2025	2028
2	21 аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс	Монгол Улсын үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн акт	2025	2028

Хүснэгт 11. Олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан байдал

д/д	Байгууллагын нэр	Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр	Хэрэгжих хугацаа	
1	Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Европын хөрөнгө оруулалтын банк	“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл	2023	2029
2	Азийн хөгжлийн банк	“Хүртээмжтэй тогтвортой хөгжлийн дэмжих нь” техник туслалцааны төсөл	2021	2025
3	Азийн хөгжлийн банк	“Бүс нутгийн болон дэлхийн эдийн засагт тогтвортой, хүртээмжтэй интеграцийг дэмжих нь” техник туслалцааны төсөл	2023	2025
4	Азийн хөгжлийн банк	“Төрийн нөөцийн удирдлага, хувийн хэвшлийн хөгжил, санхүүгийн салбарын гүйцэтгэлийг бэхжүүлэх нь” техник туслалцааны төсөл	2023	2026
5	Азийн хөгжлийн банк	“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь” техник туслалцааны төсөл	2021	2025
6	Азийн хөгжлийн банк	“Уур амьсгалын шинэ эдийн засагт уур амьсгал-ухаалаг уул уурхай” техник туслалцааны төсөл	2023	2026
7	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)	“Эдийн засгийг төрөлжүүлэх нөхцөлийг сайжруулах нь” техник туслалцааны төсөл	2024	2026

Зүраг 5. Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагаанд холбогдогч талvvд



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 12. Холбогдогч талуудын оролцоо

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Бусад
УИХ	√	√	√	√	√	-
ЗГ	√	√	√	√	√	-
ЗГХЭГ	√	√	√	√	√	-
Яам	√	√	-	-	√	-
Оюуны өмчийн газар	√	√	√	√	√	-
ЗГ-ын агентлаг	-	√	-	√	√	-
ШУА, ШУТС болон бусад	√	√	√	√	√	-
Нутгийн захиргааны байгууллага	√	√	√	√	-	-
Олон улсын байгууллага	√	√	√	√	-	-
Сургалт, судалгааны байгууллага	√	√	√	√	-	-
Иргэд, ААН	√	√	√	√	-	-

Хүснэгт 13. Санхүүгийн нөөц, батлагдсан төсөв, сая төгрөгөөр

д/д	Хөтөлбөр	2024 он	2025 он	2026 он	2027 он
1	Эрдэм, шинжилгээ судалгааны ажил	693.9	900.0	990.0	1,089.0
2	Мэдээлэл сурталчилгааны зардал	126.9	187.4	206.1	226.7
3	Тээврийн үйлчилгээ	52.3	-	57.5	63.2
4	Улс орноо гадаадад сурталчлах	51.0	-	56.1	61.7
5	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,247.2	10,330.3	11,363.3	-
6	Гадаадын болон Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	269.5	197.8	217.6	239.3
7	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	58.2	72.6	79.8	87.7
8	Олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах	302.9	315.0	346.5	381.1
9	Монгол судлалын үйл ажиллагаа	512.0	-	563.2	619.5
10	Байр ашиглалтын үйлчилгээ	441.5	590.7	649.7	714.6
11	Хөрөнгө оруулалтын бодлого	25,000.0	107,132.1	100,000.0	100,000.0
		40,000.0	20,000.0	22,000.0	24,200.0
12	Урсгал төсөв	9,558.5	10,770.2	11,847.2	13,031.9
	НИЙТ ДҮН	78,313.9	139,725.9	148,377.0	140,714.7

Хүснэгт 14. Давхардсан чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагууд

д/д	Үйл ажиллагаа нь давхардсан байгууллагын нэр	Яамдын чиг үүрэг: Давхцал үүсэж буй үйл ажиллагаа	Эдийн хөгжлийн чиг үүрэг	засаг, яамны	Тайлбар
1	Цахим хөгжил, инновац харилцаа, холбооны яам	Цахим хөгжил, инновац харилцаа, холбооны яамны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр: 2.4.2.мэдээллийн технологи, цахим засаглал болон нийтийн мэдээллийн дэд бүтэц, инновац, үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;	Яамны стратегийн зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн: 2.2.3.шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох; 2.4.3.шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;		Инновацийн шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй, хүртээмжтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлохоор туссан байна. Энэ нь Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-ийн 20/-д: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд “өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны бодлого, төлөвлөлт, хөгжүүлэх асуудал”-ыг бүхэлд нь хариуцуулахаар тогтоосон заалтыг зөрчсөн байна. Мөн Засгийн газрын 2024 оны “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 06 дугаар тогтоолын 3-т: “Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газар, 2 хэлтэстэй, үүний дотор “Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтэстэй” байхаар заасан нь дээрх хуулиар олгосон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын чиг үүргийн эрх олгосон заалтыг зөрчиж байна. Нөгөө талаас хуулиар олгосон чиг үүргийг Эдийн засаг,

			төлөвлөлтийг тодорхойлох; 2.5.3.4.шинжлэх ухааны судалгаа, дэвшилтэт технологи, инновацыг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх замаар аж ахуйн нэгжүүдийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлого боловсруулах, зохицуулах.	хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй чиг үүргээр Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газарт шинэ бүтцийн нэгж байгуулсан нь дээрх хуулийн заалтыг зөрчихөөс гадна яамд хоорондын чиг үүргийн давхардал үүсгэсэн байна.
2	Гадаад харилцааны яам, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар	Засгийн газрын тухай хууль 20 дугаар зүйл. 8/Гадаад харилцааны сайд: -гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа; -гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа; -гадаад худалдааны хэрэгжилт; -гадаадад байгаа Монгол Улсын иргэн, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал; -гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт; -гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээрх хамтын ажиллагаа; -дипломат, албан зэргийн виз, консулын асуудал; -гадаад сурталчилгаа;	Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газар: 2.2.4.хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох, тохиролцох;	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, бодлогыг тодорхойлдог.

3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Үнэлгээ, мониторингийн баг.	Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм: 5.11. Үнэлгээ, мониторингийн баг дараах үндсэн чиг үүрэгтэй. 5.11.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, энэ чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, үр дүнг нэгтгэх;	Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар: 2.5.8.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах;	Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дах заалтад Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга: хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал туссан нь давхардал бий болгоод байна.
---	---	---	---	---

Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэг хэрэгжүүлэх эрх хэмжээ нь олгогдсон хэдий ч зарим чиг үүргийг давхардуулж олгосон нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байна. Тухайлбал, Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны яамны чиг үүрэгт "инновацийн бодлогын асуудал", Гадаад Харилцааны яамны чиг үүрэгт "худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын асуудал", ЗГХЭГ-ын харьяа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт "хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих" асуудлыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал" гэж туссан мөн "Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм: 5.11. Үнэлгээ, мониторингийн баг дараах үндсэн чиг үүрэгтэй. 5.11.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, энэ чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, үр дүнг нэгтгэх," гэж туссан бөгөөд Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн "Эдийн засаг, хөгжлийн яамны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тооны хязгаар батлах тухай" 24 дүгээр тогтоолын 2.5.8.1 заалтад "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах" гэж туссан нь давхцал үүсгээд байна.

Иймд Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт бодлогын түвшинд төлөвлөлтийг зангидах, бусад яамдыг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгох нь зүйтэй байна.

Хүснэгт 15. Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар

ЕЧҮ	ДЧҮ	Арга хэмжээ	Үнэл гээн ий хувь	ЕЧҮ	ДЧҮ
3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ					
3.1.		Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлно.	90	90	-
	3.1.1.	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан төслийн эхний хувилбарыг боловсруулна.	100	-	100
	3.1.2.	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	100	-	100
	3.1.3.	Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	100	-	100
	3.1.4.	"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.	100	-	100
3.2.		Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө.	100	100	-
	3.2.1.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг боловсруулна.	90	-	90
	3.2.2.	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	90	-	90
	3.2.3.	Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангана.	90	-	90
	3.2.4.	Монгол Улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгнө.	100	-	100
	3.2.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.	90	-	90
	3.2.6.	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, санал өгнө.	90	-	90
	3.2.7.	Эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.	90	-	90
	3.2.8.	Судалгаа, шинжилгээ хийх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэн байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	100	-	100

	3.2.9	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулж, нэвтрүүлнэ.	70	-	70
	3.2.10.	Хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи судлах, нутагшуулах, хөгжүүлэлтийг дэмжинэ.	70	-	70
	3.2.11.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, мэдээллийг эргэлтэд оруулна.	70	-	70
3.3.		Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.	100	100	-
	3.3.1.	Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.	100	-	100
	3.3.2.	Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.	100	-	100
	3.3.3.	Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.	100	-	100
3.4.		Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.	90	90	-
	3.4.1	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна.	100	-	100
	3.4.2.	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.	100	-	100
	3.4.3.	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	100	-	100
	3.4.4.	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.	100	-	100
	3.4.5.	Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон төсвийн тухай хуулийн танилцуулгад тусгана.	100	-	100
	3.4.6.	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	90	-	90
	3.4.7.	Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг боловсруулна.	100	-	100
3.5.		Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ.	100	100	-
	3.5.1.	Монгол Улсын төсвийн дунд хугацааны эрсдэлийг тодорхойлж тайлан танилцуулга бэлтгэн, удирдлагад танилцуулна.	100	-	100
	3.5.2.	Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайлан бэлтгэж удирдлагад танилцуулна.	100	-	100

	3.5.3.	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна.	100	-	100
	3.5.4.	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	100	-	100
3.6.		Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.	100	100	-
	3.6.1.	Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг Өв уламжлалын сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс"-г тулгуурлан судалж шаардлагатай тоо, мэдээллийг цуглуулан сан үүсгэж дүн шинжилгээ хийнэ.	100	-	100
	3.6.2.	Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр санал боловсруулж танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулна.	100	-	100
	3.6.3.	Эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэж ажиллана.	100	-	100
3.7.		Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр хууль тогтоомж, урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулна.	100	100	-
	3.7.1.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалын хамт батлуулна.	100	-	100
	3.7.2.	Шинжлэх ухааны паркийн эрхзүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулна.	100	-	100
	3.7.3.	Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг 2025-2028 онд хөгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	90	-	90
	3.7.4.	Технологи дамжуулах хөтөлбөрийг боловсруулж, батлуулна.	90	-	90
	3.7.5.	Шинжлэх ухаан, технологийн төслийн зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмыг батлуулна.	100	-	100
	3.7.6.	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, ашиглуулах журмыг шинэчлэн батлуулна.	90	-	90
	3.7.7.	Шинжлэх ухаан, технологийн төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах аргачлалыг шинэчлэн батлуулна.	90	-	90
	3.7.8.	Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын захирлын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, батлуулна.	90	-	90
	3.7.9.	Шинжлэх ухаан, технологи, инновацын Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна.	100	-	100
	3.7.10.	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулна.	100	-	100
	3.7.11.	Яамдын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг боловсруулж, батлуулна.	90	-	90
3.8.		Шинжлэх ухаан, технологи, инновацын үйл ажиллагааны хэрэгжилт, зохицуулалтыг ханган ажиллана.	100	100	-

	3.8.1.	Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл сонгон шалгаруулж, шалгарсан бүтээлийг урамшуулах ажлыг зохион байгуулна.	100	-	100
	3.8.2.	Шинжлэх ухааны ажилтны өдрийг угтсан "Шинжлэх ухаан, технологи-инновац-2024" сарын арга хэмжээг зохион байгуулна.	100	-	100
	3.8.3.	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт 2024 оноос эхлэн хэрэгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	100	-	100
	3.8.4.	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гаргана.	100	-	100
	3.8.5.	Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлд санхүүжилт олгох ажлыг зохион байгуулна.	100	-	100
	3.8.6.	Шинжлэх ухаан, технологийн Үндэсний хороо болон салбарын харьяа байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.	100	-	100
	3.8.7.	Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулна.	100	-	100
	3.8.8.	Монгол судлалын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	100	-	100
	3.8.9.	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлыг удирдлагаар хангаж ажиллана.	100	-	100
3.9.		Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавина.	100	100	-
	3.9.1.	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтлан ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авна.	100	-	100
	3.9.2.	Худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч салбар хоорондын уялдааг хангана.	100	-	100
	3.9.3.	Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлон, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавина.	100	-	100
	3.9.4.	Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ өвч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	100	-	100
	3.9.5.	Нэгжийн худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах чиглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавина.	70	-	70
3.10.		Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах,	100	100	-

		хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.			
	3.10.1	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах, сайжруулах санал боловсруулна.	100	-	100
	3.10.2.	Гадаадын хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.	90	-	90
	3.10.3.	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавина.	100	-	100
	3.10.4.	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	100	-	100
3.11.		Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, эрэмбэлэх, хянан баталгаажуулах, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийлгэх, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулна.	100	100	-
	3.11.1.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалыг шинэчлэн боловсруулна.	100	-	100
	3.11.2.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх саналыг хүлээн авч, эрэмбэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулна.	100	-	100
3.12.		Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулна.	100	100	-
	3.12.1.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан гарах журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана.	100	-	100
	3.12.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон тус хуулийг дагалдан гарсан журам, аргачлалын хүрээнд сургалтыг зохион байгуулна.	100	-	100
	3.12.3.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллана.	100	-	100
	3.12.4.	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	100	-	100
	3.12.5.	Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	100	-	100
	3.12.6.	Монгол Улсын 2024 оны төсөвт батлагдсан концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төслүүдийн санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэнэ	100	-	100

	3.12.7.	Монгол Улсын 2025 оны төсөвт концессын төслийн санал хүргүүлнэ. /Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт болон Концессын төлбөрийн орлого/	100	-	100
	3.12.8	Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавина.	100	-	100
3.13.		Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавина.	100	100	-
	3.13.1.	Монголын ногоон санхүүгийн корпорац (МНСК)-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагааг нь эхлүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	100	-	100
	3.13.2.	Ногоон санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох суурь судалгааны ажлыг эхлүүлж, холбогдох талуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	100	-	100
3.14.		Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавина.	90	90	-
	3.14.1.	Монгол Улсын зэс, зэсэн бүтээгдэхүүн, төмөр, ган, металл, арьс шир, ноос ноолуур, хувцас үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар мэдээллийн сан үүсгэнэ.	100	-	100
	3.14.2.	Орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сангийн бүтэц, платформын судалгааг эхлүүлнэ.	100	-	100
	3.14.3.	Аж үйлдвэрийн төлөвлөлтийн бодлогыг орон зайн судалгаанд суурилж бусад төрийн байгууллагын мэдээллийн сангуудыг цуглуулна.	100	-	100
3.15.		Эдийн засгийн салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийж, салбаруудын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, либералчлалын бодлогыг тодорхойлж, холбогдох байгууллагууд, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдтэй хамтатган үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавина.	90	90	-
	3.15.1.	Монгол Улсын зэс, зэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна.	90	-	90
	3.15.2.	Монгол Улсын төмөр, ган үйлдвэрлэлийн чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна.	90	-	90
	3.15.3.	Монгол Улсын металл бус эрдэс бодисоор хийсэн барилгын материал үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна.	90	-	90
	3.15.4.	Монгол Улсын арьс шир, ноос ноолуур, хувцас үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, зах зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нарийвчилсан судалгаа боловсруулна.	90	-	90
	3.15.5.	Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.	90	-	90
3.16.		Хувийн хэвшлийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад төрийн оролцоог багасгах үндсэн чиглэлийн бодлого боловсруулах, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг	90	90	-

		тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулна.			
	3.16.1.	Хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн тулгамдаж буй асуудал тодорхойлох, шаардлагатай хууль зүйн орчныг сайжруулах талаар судалгаа боловсруулна.	90	-	90
	3.16.2.	Жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих бодлого, тогтолцоог хөгжүүлж, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаална.	90	-	90
3.17.		Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эдийн засгийн коридорын төслүүдийг идэвхжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	90	90	-
	3.17.1.	Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулна.	90	-	90
	3.17.2.	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төслүүдэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	90	-	90
3.18.		Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангана.	90	90	-
	3.18.1.	Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	70	-	70
	3.18.2.	Хөгжлийн төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангана.	90	-	90
3.19.		Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавина.	90	90	-
	3.19.1.	Эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцоно.	100	-	100
	3.19.2.	Төсөл хөтөлбөрүүдийг тохиролцож, хэрэгжилтэд хяналт тавина.	70	-	70
4.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ					
4.1.		Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангана.	100	100	-
	4.1.1.	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж дүгнүүлнэ.	100	-	100
	4.1.2.	Яамны үйл ажиллагаатай холбогдох төлөвлөгөөг боловсруулах, батлуулна.	90	-	90
	4.1.3.	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хэвийн явуулна.	100	-	100
	4.1.4.	МУ-ын ерөнхийлөгчийн зарлиг, УАБЗ-ийн зөвлөмж, УИХ-ын болон ЗГ-ын тогтоол, ЕС-ын захирамж, албан даалгавар, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл хууль, тогтоомжийн биелэлтийг сар бүр болон хагас, бүтэн жилээр газруудаас нэгтгэн авч, холбогдох газарт хүргүүлнэ.	70	-	70
	4.1.5.	Яамны үйл ажиллагаатай хамааралтай тайланг гаргана.	90	-	90
	4.1.6.	Сайдын болон ТНБД-ын шуурхай хуралдааныг зохион байгуулах, тухай бүр үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, танилцуулна.	100	-	100
	4.1.7.	Мэдээллийн системүүдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн нууцлал, аюулгүй байдал болон байнгын найдвартай ажиллагааг хангана.	100	-	100
	4.1.8.	Гадаад, дотоод сургалтын тушаал боловсруулах, гадаад оронд сургалтад явах виз авах бичиг баримтыг холбогдох	100	-	100

		байгууллагад хүргүүлэх, сургалтын тайланг мэдээллийн цагийг зохион байгуулна.	авч нэгтгэн			
	4.1.9.	Архивын баримтаас мэдээ, лавлагаа олгоно.		100	-	100
	4.1.10.	Яамны цахим хуудсаар дамжуулан иргэн, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.		100	-	100
	4.1.11.	Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын өдөр тутмын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэнэ.		100	-	100
	4.1.12.	Яамны дайчилгааны төлөвлөгөө батлуулсан байна.		90	-	90
	4.1.13.	Яамны бодлого, үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн харилцааг зохицуулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.		100	-	100
	4.1.14.	Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлнэ.		90	-	90
4.2.		Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлнэ.		100	100	-
	4.2.1.	Жагсаалтад туссан төслөөс Төрийн худалдан авах ажиллагааны газраас тендер сонгон шалгаруулж, шалгарсан компанитай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна.		100	-	100
	4.2.2.	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг хянана.		100	-	100
	4.2.3.	Засгийн газрын болон яамтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.		100	-	100
	4.2.4.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.		100	-	100
	4.2.5.	Долоо хоног бүрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хүргүүлсэн саналуудын жагсаалтыг нэгтгэн боловсруулна.		100	-	100
	4.2.6.	Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэнэ.		100	-	100
	4.2.7.	Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, яамны нэгжүүдийг авлигын эсрэг мэдээллээр хангана.		100	-	100
	4.2.8.	Нууцын асуудлыг эрхлэн хөтөлнө		100	-	100
4.3.		Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.		90	90	-
	4.3.1.	Албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.		100	-	100
	4.3.2.	Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлж, туршлага солилцох боломжийг бүрдүүлнэ.		100	-	100
	4.3.3.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах мэдээ мэдээллийг цахим хуудсанд оруулах, хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гаргах, Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.		90	-	90
	4.3.4.	Яамны болон эдийн засгийн салбарын ажилтан нарыг шагнуулахаар тодорхойлсон ажилтнуудад холбогдох журмын дагуу шагнал урамшууллыг олгоно.		100	-	100
	4.3.5.	Төрийн жинхэнэ албан хаагчийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлнэ.		100	-	100

	4.3.6.	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох байгууллагад тайланг хүргүүлнэ.	90	-	90
	4.3.7.	Жендерийн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангана.	90	-	90
4.4.		Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнана.	100	100	-
	4.4.1.	Байгууллагын санхүү, төсвийн асуудлыг эрхлэн гүйцэтгэж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг явуулна.	100	-	100
	4.4.2.	Яамны албан хаагчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнана.	100	-	100
	4.4.3.	Байгууллагын шилэн дансны мэдээлэл оруулна.	90	-	90
	4.4.4.	Газрын чиг үүрэг хамаарах худалдан авах ажиллагааг зохион байгуулна.	100	-	100
	4.4.5.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын төслийн саналыг нэгтгэн, боловсруулна.	100	-	100
	4.4.6.	Яамны хөрөнгийн тооллого хийнэ.	100	-	100
	4.4.7.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг нэгтгэн гаргана.	100	-	100
	4.4.8.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг шуурхай олгох арга хэмжээ авна.	100	-	100
4.5.		Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.	100	100	-
	4.5.1.	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
	4.5.2.	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
	4.5.3.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
	4.5.4.	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
	4.5.5.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	100	-	100
	4.5.6.	Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
	4.5.7.	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний	100	-	100

		хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.			
4.5.8.		Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
4.5.9.		Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	90	-	90
4.5.10.		Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийнэ.	100	-	100
4.5.11.		Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
4.5.12.		Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	100	-	100
4.5.13.		Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	100	-	100
4.5.14.		Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
4.5.15.		Байгууллагын 2023 оны ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	100	-	100
4.5.16.		Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийнэ.	90	-	90
Нийт дүн			96.6		
Ерөнхий чиг үүргийн дундаж үнэлгээ				95.9	
Дэд чиг үүргийн дундаж үнэлгээ					96.7

Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг дүгнэн үзвэл 24 зорилтын 142 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ хийхэд 96.6 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Ерөнхий чиг үүргийн 24 зорилтын биелэлт буюу дундаж үнэлгээ 95.9 хувь, дэд чиг үүргийн буюу 118 арга хэмжээний биелэлтийн дундаж үнэлгээ 96.7 хувь буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хүрсэн байна.

Хүснэгт 16. Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэг, захиргааны эрх хэмжээний ангиллаар

дд	Чиг үүрэг	Захиргааны эрх хэмжээ						
		Бодлого боловсруулах	Зохицуулах	Зохион байгуулах	Санхүүжүүлэх	Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх	Үйлчилгээ үзүүлэх	Хяналт тавих
Нэг.	Ерөнхий чиг үүрэг-1. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;							

ҮЧҮ	1.1.	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу бүс нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэл, нийгмийн хөгжлийн бодлого, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд холбогдох мэдээллээр яамны бусад нэгжийг хангах;	+	+	+		+		
ҮЧҮ	1.2.	Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, салбар хоорондын бодлогыг уялдуулж, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;	+	+	+		+		+
ҮЧҮ	1.3.	Нийгмийн тогтвортой хөгжлийн бодлого, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;	+	+	+		+		+
Хоёр.		Ерөнхий чиг үүрэг-2. Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах							
ҮЧҮ	2.1.	Макро эдийн засгийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой өсөлтийг хангах бодлогын чиглэлийг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт хийх, эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний санал, төлөвлөгөө боловсруулах;	+				+		
ҮЧҮ	2.2.	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулах, төсөв, төрийн санхүүгийн төлөв байдлыг тодорхойлох, төсөөлөл боловсруулах, тулгарч болох болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний санал, төлөвлөгөө боловсруулах;	+				+		

ҮЧҮ	2.3.	Улсын эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор нэгдсэн тооцоолол, судалгаа, шинжилгээнд үндэслэн холбогдох бүх шатны төрийн байгууллагуудыг бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалт, зөвлөмжөөр хангах;	+	+			+		
Гурав.		Ерөнхий чиг үүрэг-3. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох;							
ҮЧҮ	3.1.	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;	+	+	+	+	+		+
ҮЧҮ	3.2.	Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	+	+			+		
ҮЧҮ	3.3.	Шинжлэх ухааны нотолгоонд суурилсан дэвшилтэт технологи, инновацыг тэргүүлэх салбаруудад нутагшуулах замаар эдийн засгийн эрчимтэй хөгжлийг бий болгох бодлого, зохицуулалт хийх;	+	+			+		
Дөрөв.		Ерөнхий чиг үүрэг -4. Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох, тохиролцох;							
ҮЧҮ	4.1.	Худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;	+	+			+		
ҮЧҮ	4.2.	Импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, шинээр гэрээ хэлцэл байгуулах санал гаргах, боловсруулах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж,	+	+			+		

		хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;							
ҮЧҮ	4.3.	Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, яамны гадаад харилцааны асуудлыг эрхлэн гүйцэтгэх;	+	+			+		
Тав.		Ерөнхий чиг үүрэг-5. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, ногоон санхүүжилтийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;							
ҮЧҮ	5.1.	Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;	+	+	+		+	+	+
ҮЧҮ	5.2.	Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хөрөнгө оруулалтын бодлого, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн төслүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулж төслийн санхүүжилтийн төлөвлөлт, эдийн засаг, санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх, бэлэн байдал хангагдсан төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	+	+	+		+		+

Ү Ч Ү	5.3.	Ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах арга хэмжээ, ногоон эдийн засаг, тогтвортой санхүүжилтийн бодлогыг салбарын яамтай уялдуулан боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эх үүсвэр татах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг тодорхойлох, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих цогц арга хэмжээг зохион байгуулах;	+	+	+	+	+	+	+
ҮЧҮ	5.4.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээг холбогдох хууль, журамд заасны дагуу салбарын яам, түншлэлийн төвөөр хийлгэх, хамтран оролцох, хяналт тавих, түншлэлийн төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах, түншлэлийн төслийн саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, түншлэлийн төслийн уралдаант сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээний биелэлт, явц, үр дүнд хяналт тавих арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;	+	+	+	+	+	+	+
Зургаа.		Ерөнхий чиг үүрэг-6. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;							
ҮЧҮ	6.1.	Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	+	+	+	+	+	+	+
ҮЧҮ	6.2.	Салбаруудын үр ашиг, бүтээмжийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа хийх, бизнесийн орчныг дэмжих, учирч буй хүндрэлийг бууруулах, өмчийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого зохицуулалт хийх, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах, тэдний санал гомдлыг хүлээн авах мэдээллийн нэгдсэн сан	+	+	+		+		+

		бүрдүүлэх, холбогдох төрийн байгууллагуудад санал боловсруулах, жижиг, дунд болон гарааны бизнесийг дэмжих, бойжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн олон талт, бодитой арга хэмжээг хэрэгжүүлэх;							
ҮЧҮ	6.3.	Аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлтийг орон зайн судалгаанд тулгуурлан тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, орон зайн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;	+	+	+		+		+
